



Нээлтэй Нийгэм Форум



Глоб Интернэшнл Төв

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**Хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг
дэмжих нь**

Глоб Интернэшнл Төв

Төслийн тайлант хугацаа: 2013.07.01- 2014.01.01

Холбоо барих: Х.Наранжаргал

hnaran@globeinter.org.mn Утас: 99288924

Т.Аюуижав globe@globeinter.org.mn Утас: 99035470

Хаяг:

Глоб Интернэшнл Төв

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо

Дипломат 95 цогцолбор,

5-орц, 57 тоот

Улаанбаатар-15141, Монгол улс

Утас: 324627, 324764

Факс: 324764

Цахим хуудас: www.globeinter.org.mn

Улаанбаатар, 2013

АГУУЛГА

I. Оршил

II. Төслийн үр дүн

2.1. Төслийн гарц

2.2. Төслийн орц

III. Төслийн үйл ажиллагаа

3.1. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бүртгэл

3.2. Эрх зүйн зөвлөгөө

3.3. Глоб Интернэшнл Төвийн үйлдэл

3.4. Орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт

V. Төслийн үнэлгээ

5.1. Үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ

VI. Асуудал, бэрхшээл

VII. Дүгнэлт

VIII. Санхүүгийн тайлан

IX. Хавсралт

I. Оршил

“Глоб Интернэшнл Төв нь Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр 2012 оны 12-р сараас 2014 оны 12-р сар хүртэл 2 жилийн хугацаатай “Хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь. Хэвлэлийн эрх чөлөөний мониторинг” төсөл хэрэгжүүлж байна.

Төсөл нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийснээр тэдний эрх, хараат бус байдлыг хамгаалах, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд хувь нэмэр оруулах зорилготой болно.

Төслийн тайлант хугацаанд сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн тухай мэдээллийг олон нийтэд түгээх, нөлөөллийн кампанит ажил зохион байгуулах, мэргэжлийн эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдэд эрх зүйн тусламж үзүүлж, тэднийг хамгаалах, хөдөө орон нутгийн өмгөөлөгчдөд сэтгүүлчдийг өмгөөлөх чадвар эзэмшүүлэх зорилтуудаа амжилттай биелүүлэв.

Төслийн тайлант хугацаанд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулав. Үүнд:

1. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бүртгэл
2. Эрх зүйн зөвлөгөө
3. Глоб Интернэшнл Төвийн үйлдэл
4. Өмгөөлөгчдөд зориулсан сургалт

II. Төслийн үр дүн

Төсөл тайлант хугацаанд зорилтуудаа амжилттай биелүүлэв:

Зорилт 1: Онлайн мониторингийн тогтвортой системээр дамжуулан сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн тухай мэдээллийг олон нийтэд түгээж, нөлөөллийн кампанит ажил зохион байгуулах

Төслийн тайлант хугацаанд 10 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой мэргэжлийн эрхийн 11 зөрчлийн тохиолдол бүртгэж, 1 шуурхай мэдээ боловсруулж, дотоод болон олон улсын сүлжээгээр түгээв. Манай “self-alerting” мониторингийн системийг ашиглах талаар сэтгүүлчдэд байнга мэдээлэл түгээж буй боловч, тэд нийгмийн сүлжээг ашиглахыг илүүд үздэг болсон байна. Манай илгээсэн шуурхай мэдээг дэлхийн 90 гаруй байгууллагыг сүлжээндээ нэгтгэсэн чөлөөт илэрхийллийн олон улсын сүлжээ IFEX дэмжиж, гишүүн байгууллагууддаа түгээв. Төслийн тайлант хугацаанд нөлөөллийн кампанит ажил зохион байгуулах шаардлага тулгараагүй.

Зорилт 2: Мэргэжлийн эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдэд эрх зүйн тусламж үзүүлж, тэднийг хамгаалах

Мэргэжлийн эрх нь зөрчигдсөн 7 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад эрх зүйн зөвлөгөө өгч, 1 сэтгүүлчийн хэрэг дээр мониторинг хийж, шат шатны шүүх хуралд нь

ажиглагчаар оролцон, 1 сэтгүүлчид стратегийн өмгөөлөл үзүүлэх төсөл бичиж, 2 сэтгүүлчид өмгөөллийн туслалцаа үзүүлж, эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдийн эрхийг хамгаалах хүрээнд албан тушаалтнуудад 1 эсэргүүцлийн захидал, 1 албан захидал илгээсэн нь зохих үр дүнгээ өгөв. Тухайлбал:

- МҮОНТ-ийн сэтгүүлч М.Бямбасүрэнд “цагаан будаанаас хар тугалга илэрлээ” сурвалжлагаас нь үүдэн олон талаас дарамт ирсэн, мөн тухайн сэдвээ үргэлжлүүлэх хүсэлтэй, манай улсад хараат бус лаборатори байхгүй, хоол хүнсэнд өдөр тутам хэрэглэдэг цагаан будаатай холбоотой асуудал нь олон нийтийн санаа зовоож буй асуудал мөн зэргийг харгалзан, манай байгууллагаас ННФ-д төслийн санал хүргүүлж, батлуулав. Уг төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэд хэдэн ТББ-ууд хамрагдан, ажиллаж байна.
- Орхон аймгийн “Нар туссан цаг” сонины редакцид аймгийн Ардчилсан холбооноос мэдээллийн нууц эх сурвалж шаардсан албан бичиг ирүүлсэнд манай байгууллагаас эсэргүүцэж, байр сууриа илэрхийлэн, сэтгүүлчдэд эрх зүйн зөвлөгөө өгөв. Манай зөвлөсний дагуу, редакцийн зүгээс тус холбооны албан бичигт хариу явуулж, мөн сонин дээрээ энэ асуудлаар байр сууриа илэрхийлсэн нийтлэл бичжээ. Ингэсний үр дүнд мэдээллийн нууц эх сурвалж шаардсан МоАХ-ноос үйлдлээ зогсоов.
- Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэст сэтгүүлч А.Баттөрд холбогдох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох албан хүсэлт илгээсний үр дүнд сэтгүүлчид холбогдох Эрүүгийн хэргийг хэрэгсэхүй болгов.

Зорилт 3: Хөдөө орон нутгийн өмгөөлөгчдөд сэтгүүлчдийг өмгөөлөх чадвар эзэмшүүлэх

Глоб Интернэшнл Төв 2013 оны 10-р сарын 28-нд орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт зохион байгуулав. Уг сургалтад Орхон, Дархан, Булган, Өмнөговь, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг болон УБ хотын ХМБ-ын 11 хуульч, өмгөөлөгч харагдаж, сэтгүүлчдийг өмгөөлөх чадвар эзэмшиж, цаашид хамтран ажиллах тохиролцоонд хүрэв.

2.1 Төслийн гарц

- 10 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой мэргэжлийн эрхийн 11 зөрчлийн тохиолдол бүртгэв.
- “Тэргүүн” сонины 3 сэтгүүлчдэд Эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхээс тэдэнд хэт өндөр торгууль ногдуулсныг эсэргүүцэж шуурхай мэдээ түгээв.
- “Тэргүүн” сонины 3 сэтгүүлчдэд Эрүүгийн хэргээр гомдол гаргасан Ерөнхий сайд Н.Алтанхуягт хэргийг хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэхийг зөвлөсөн албан захидал илгээв. Үүний үр дүнд ЕС-ын өмгөөлөгч, ЗГХЭГ-ын Хуулийн хэлтсийн дарга Н.Энхтуяа тэргүүн Х.Наранжаргалтай энэ асуудлаар уулзах хүсэлт тавив.
- Глобын гадаад сүлжээгээр илгээсэн шуурхай мэдээ IFEX олон улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ дэмжиж, цахим хуудсандаа байршуулж, гишүүн байгууллагууддаа түгээв.
- Сэтгүүлч А.Баттөрд үүсгэсэн Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай дүүргийн цагдаагийн хэлтэст 1 албан хүсэлт илгээв.
- Мэргэжлийн эрх нь зөрчигдсөн 6 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад эрх зүйн зөвлөгөө өгөв
- МҮОНТ-ийн 1 сэтгүүлчид стратегийн өмгөөлөл үзүүлэх төсөл бичиж, батлуулав.

- 2 сэтгүүлчид өмгөөллийн туслалцаа үзүүлэв.
- Өмгөөлөгчдөд зориулсан сургалтад Орхон, Дархан, Булган, Өмнөговь, Хөвсгөл, Сэлэнгэ, УБ хотын 11 хуульч, өмгөөлөгчид оролцож, сэтгүүлчдийг өмгөөлөх чадвар эзэмшив.
- Өмгөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөр, сургалтын материал бэлэн болов.

2.2 Төслийн орц

- ГИ төвийн 3 сургагч багш өмгөөлөгчдөд зориулсан сургалтад хувь нэмрээ оруулж, мэдлэг, туршлагаа хуваалцав.
- АНУ-ын 1 ахмад хуульч өмгөөлөгчдөд зориулсан сургалтад хувь нэмрээ оруулж, мэдлэг, туршлагаа хуваалцав.
- Англи-монгол хэлний 1 орчуулагч сургалтад хувь нэмрээ оруулав.
- Глоб Интернэшнл Төвийн 1 хуульч эрх зүйн зөвлөгөө өгч, өмгөөллийн туслалцаа үзүүлэв.
- Глоб Интернэшнл Төвийн 1 зохицуулагч төслийн зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэж, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийг бүртгэх, дотоод, гадаад сүлжээгээр шуурхай мэдээ түгээх, албан захидал бичих, нийгмийн сүлжээнд холбогдон, мэдээ шинэчлэх зэрэг ажил хариуцав.

III. Төслийн үйл ажиллагаа

3.1. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бүртгэл

Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, дарамт шахалт үзүүлэх, шүүх цагдаагаар сүрдүүлэх, мэдээлэл олж авах, түгээхэд нь саад хийх, нууц эх сурвалжаа илчлэхийг албадах, улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, хөрөнгө мөнгөтэй баячууд өөрсдийн буруутай үйлдлийг нуун дарагдуулахын тулд Иргэний болон Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг ашиглах, редакцийн цензур зэрэг зөрчил тасрахгүй байна.

Төслийн тайлант хагас жилийн хугацаанд Глоб Интернэшнл Төвд 10 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой мэргэжлийн эрхийн 11 зөрчлийн тохиолдол бүртгэгдлээ. Үүнээс, сонины сэтгүүлч - 4, цахим хуудасны сэтгүүлч - 1, телевизийн сэтгүүлч - 2, радио - 1 бөгөөд эдгээрийн 20% нь орон нутгаас хандсан байна. Үүнд:

- а/ “Тэргүүн” сонины ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Б.Цоожчулуунцэцэг, сэтгүүлч Б.Отгонжаргал нарт Ерөнхий сайд Н.Алтанхуягийн гомдлын дагуу Чингэлтэй дүүргийн шүүхээс нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлэг олон нийтэд тараасан, түүнчлэн сонины эрхлэгч дээрх нийтлэлүүдийг нягталж шалгалгүйгээр “бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлгийг олон нийтэд тараасан” гэмт хэрэгт тус тус холбогдуулан шалгаж, Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр Эрүүгийн хэрэг үүсгэсэн.
- б/ “Тэргүүн” сонины сэтгүүлч Л.Цэдэвсүрэнгийн тус сонины 2012 оны 5-р сарын №19(348)-д “Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг

бөхөлзөж байна” нийтлэлийн дагуу Орхон аймгийн шүүхийн ерөнхий шүүгч П.Батсайханы гомдлоор Чингэлтэй дүүргийн шүүхээс Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр Эрүүгийн хэрэг үүсгэсэн шалгажээ.

Чингэлтэй дүүргийн шүүх 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр “Тэргүүн” сонины 3 сэтгүүлчийн эсрэг Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр үүсгэсэн хэргийг хянан хэлэлцээд нийт 29 сая төгрөгийн торгуулийн ял ногдуулж, торгох ялаас зайлсхийвэл 3 жил хүртэл хугацаатайгаар хорих ялаар солихоор шийдвэрлэжээ. Мөн 2013 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн оноосон ялыг хэвээр үлдээх шийдвэр гаргасан байна. “Тэргүүн” сонины сэтгүүлчид Дээд шүүхэд хандаад байна.

Хавсралт 1. “Тэргүүн” сонинд нийтлэгдсэн материалууд

Хавсралт 2. “Тэргүүн” сонины ГИ төвд хандсан захидал

Хавсралт 3. “Тэргүүн” сонинд холбогдох хэргийн шүүх хурлын шийдвэр,

Хавсралт 4. “Тэргүүн” сонины ерөнхий эрхлэгч Б.Цоожчулуунцэцэг,

сэтгүүлч Б.Отгонжаргал, Л.Цэдэвсүрэн нарын Ерөнхий сайд

Н.Алтанхуягт хандсан захидал /харамсалтай нь уг захидлыг

ЕС-ын уурыг нь хүргэчихнэ гэдэг шалтгаанаар

албаны хүмүүс нь дамжуулаагүй байна.

в/ МҮОНТ-ийн Монголын мэдээ агентлагийн редактор М.Бямбасүрэн 2013 оны 4 сард Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрөөр “цагаан будаанаас хар тугалга илэрлээ” сурвалжлага явуулжээ. Тухайн үед худалдаанд зарагдаж байсан цагаан будааны төрөл авч МУИС-ийн Хими судлалын тэнхимийн явуулын лабораторид шинжлүүлэхэд Тесо ХХК-ийн цагаан будаанаас хар тугалганы хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их илэрсэн талаар мэдээлсэн байна. Түүний сурвалжлагаас үүдэн, “Тесо” компанийн хуулийн ажилтан сэтгүүлч рүү утасдаж дарамталжээ. Мөн МХЕГ-аас цагаан будааны үлдэгдэл дээжийг нэхэж дахин шинжилгээнд хамруулахыг шаардав. Түүгээр зогсохгүй, МҮОНРТ-ийн нэр бүхий албан тушаалтан сэтгүүлчийг зэмлэж, “Тесо” компанитай олон сая төгрөгний сурталчилгааны гэрээтэй болохыг анхааруулж, мэдээнд болгоомжтой хандахыг хүсчээ. Мөн телевизийн удирдлагуудын зүгээс “Тесо” компанид сэтгүүлчийн дараагийн сэдвийг мэдээлсэн тохиолдол гарсан байна.

Хавсралт 5. Сэтгүүлч М.Бямбасүрэнгийн ГИ төвд

эрхээ хамгаалуулахаар гаргасан хүсэлт

г/ “Улаанбаатар радио” нь Нийслэлийн Өмч Хувьчлах Комиссын 2008 оны тогтоолоор Чингэлтэй дүүрэгт байрлах үйлчилгээний төвийн барилгад 1 222 м.кв талбай бүхий байр, гүүрэн гарцыг хувьчлан авсан байдаг. Гэтэл 2013 онд шүүхээс Нийслэлийн өмч хувьчлах комиссийн тогтоолыг хүчингүй болгож, радиогийн эзэмшилд байсан байрыг хураан авахаар шийдвэрлэснийг тус радиогийн зүгээс эсэргүүцэж байна.

Хавсралт 6. “Улаанбаатар радио”-гоос гаргасан мэдэгдэл

д/ Орхон аймгийн “Нар туссан цаг” сонины 2013 оны 12 сарын 6-нд “МоАХ-ны удирдлагууд Засаг даргад бараалхжээ” нийтлэл хэвлэгджээ. Уг нийтлэлдээ тус

холбоонд өрнөж буй хууль бус явдлуудын талаар шүүмжилсэн байна. Гэтэл аймгийн Ардчилсан холбооноос мэдээллийн дээрх мэдээллийг эсэргүүцэж, мэдээллийн эх сурвалж шаардсан албан бичгийг тус сонины редакцид хүргүүлсэн байна.

Хавсралт 7. “Нар туссан цаг” сонины нийтлэл

Хавсралт 8. Аймгийн Ардчилсан холбооноос сонины редакцид явуулсан захидал

е/ Сэтгүүлч А.Баттөр нь www.chuhal.mn цахим хуудсанд нийтлэгдсэн “Интернэтээр биеэ үнэлэгчдийн жишээ” гарчигтай мэдээллээс зөвхөн зураг, гарчигийг хуулбарлан охид, эмэгтэйчүүдэд сэрэмжлүүлэг болгох үүднээс өөрийн dursamj.mn цахим хуудсанд байрлуулжээ. Тухайн мэдээнд нэгэн эмэгтэйн тухай, зурагтай нь нийтэлсэн бөгөөд тухайн эмэгтэй нүүрний ихэнх талыг нь халхалсан. Гэтэл тэр эмэгтэйн зүгээс нэр төрд халдсан гэдэг үндэслэлээр Чингэлтэй дүүргийн шүүхэд өргөдөл гаргасны дагуу, тус дүүргийн цагдаагийн хэлтсээс сэтгүүлчид Эрүүгийн хэрэг үүсгэн, байцаан шалгажээ.

Сэтгүүлч А.Баттөр манай байгууллагад хандаж, эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн тусламж хүссэн. Сэтгүүлч уг мэдээллийг олон нийтэд нэгэнт түгээгдсэн хойно нь өөрийн цахим хуудсанд хуулбарлан тавьж, ёс зүйн алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч, өөрийн болон бусад хэд хэдэн цахим хуудсаар дамжуулан залруулга мэдээллийг тавьсан байна. Сэтгүүлч нь хэдийгээр ёс зүйн алдаа гаргасан ч манай байгууллагын хуульч Д.Мөнхбүрэн энэ хэрэг дээр ажиллаж, эрх зүйн зөвлөгөө өгч, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэст сэтгүүлчид холбогдох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох талаар албан захидал явуулсан.

Хавсралт 9. ГИ төвийн ЧД цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч Д.Сайнжаргалт илгээсэн албан бичиг

ё/ “Зууны мэдээ” сонины сэтгүүлч Д.Болормаад “Мон Уран” компанийн захирал Б.Наранхүүгийн гомдлоор Сүхбаатар дүүргийн шүүхэд Эрүүгийн хэрэг үүсгэн, анхан шатны шүүхээс 2011 оны 8-р сард хэрэгсэхгүй болгож, гомдол гаргачийн зүгээс давж заалдсан учир 2012 оны 2-р сард тус дүүргийн шүүхээс нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан, 2012 оны 9 сард шүүхээс сэтгүүлчийн гэм бурууг тогтоож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 61 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.5 сая гаруй төгрөгний мөнгөн торгуулт ногдуулжээ. Нийслэлийн Дээд шүүхээс 2013 оны 5-р сард сэтгүүлчид ногдуулсан хэвээр баталсан байна. Энэ хэрэг Б.Наранхүүг УИХ-ын гишүүнээр сонгогдсоны дараа маш эрчимтэй өрнөж, сэтгүүлчийг шат шатны шүүхээс буруутгасан тогтоол гаргасан нь сонирхол татаад байна.

Хавсралт 10. Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас сэтгүүлч Д.Болормаад хүргүүлсэн мэдэгдэх хуудас

ж/ “Өдрийн шуудан” сонины сэтгүүлч Б.Эрдэнэцэцэгт холбогдох Эрүүгийн хэрэг дээр манай байгууллага мониторинг хийж байна. Сэтгүүлч Ц.Эрдэнэцэцэг “Өдрийн шуудан” сонины 2012 оны 11-р сарын 9-ний өдрийн дугаарт болон www.news.mn цахим хуудсанд “Дугаарын бизнес дундраагүйгээр барахгүй илүү нарийн, илүү цадиггүй болон хөгжиж байна” гарчигтай нийтлэл гарчээ. Уг нийтлэлд авто машины азын гэгддэг ижил тоотой дугаарыг албан тушаалын давуу байдлаа ашиглан алба

тушаалтнууд иргэдэд зардаг, танил талдаа өгдөг, ингэснийхээ хөлсийг хээл хахууль маягаар авдаг байдал газар авсан талаар бичжээ. Нийтлэлд нэр нь дурдагдсан Авто тээврийн газрын хэлтсийн даргаар ажиллаж байсан, өдгөө Зам тээврийн яамны Хяналт бүртгэлийн газрын дарга Б.Жаргал Сүхбаатар дүүргийн цагдаад Эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргасаны дагуу сэтгүүлч Эрдэнэцэцэгт 2013 оны 1-р сард Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр хэрэг үүсгэжээ. Жаргалын энэ үйлдлийг эсэргүүцэж, манай байгууллагаас захидал явуулсныг өмнөх тайландаа дурдсан. Сүхбаатар дүүргийн шүүхэд 2013 оны 6 сарын 21-нд болсон анхан шатны шүүх хурлаар сэтгүүлчтэй холбоотой хэргийг цагаатгасан. Хохирогч Жаргалын давж заалдах шатны шүүхэд өргөдөл гаргасны дагуу, 2013 оны 9 сард Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс сэтгүүлчид холбогдох хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаах шийдвэр гаргажээ.

3.2. Эрх зүйн зөвлөгөө

- “Тэргүүн” сонины ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Б.Цоожчулуунцэцэгт эрх зүйн зөвлөгөө өгсөн. Мөн АНУ-ын ахмад хуульчдийн төслийн ахмад хуульч Дэниэл Байрон сэтгүүлчтэй уулзаж, зөвлөгөө өгч, ийм төрлийн хэргийн АНУ-д хэрхэн шийддэг талаар сонирхуулав. АНУ-д тухайн хүн өөрийн хүүхэд гэдэг мэдээллийг няцааж, хэрэг үүсгэх тохиолдолд шууд ДНК-ийн шинжилгээ тогтоодог юм байна. Харин манайд мөрдөн байцаагч, шүүхийн талынхан бүгд Ерөнхий сайдын талд үйлчилж буй тухай дурдав.
- МҮОНТ-ийн сэтгүүлч М.Бямбасүрэнд “цагаан будаанаас хар тугалга илэрлээ” сурвалжлагаас нь үүдэн олон талаас дарамт ирсэн тул манай байгууллагад хандсан. Сэтгүүлч хар тугалга илэрсэн будааны дээжээ хадгалж байгаа бөгөөд энэ сэдвээ үргэлжлүүлэх хүсэлтэй байгаа ч хэрэгт орхоос эмээж байв. Хоол хүнсэнд хэрэглэж буй цагаан будаанаас хар тугалга илэрсэн тухай асуудал нь олон нийтийн санаа зовоож буй асуудал мөн тул манай байгууллага анхаарал хандуулж, сэтгүүлчид эрх зүйн зөвлөгөө өгөх, энэ асуудлыг цаашид судлах, цагаан будааг хараат бус лабораториор шинжлэх асуудлаар ННФ-д хандаж, төсөл бичсэнээр хэд хэдэн ТББ-уудын хамтарсан төсөл хэрэгжиж эхэлсэн.
- Шүүхээс Нийслэлийн өмч хувьчлах комиссийн тогтоолыг хүчингүй болгож, “Улаанбаатар радио”-гийн эзэмшилд байсан байрыг хураан авахаар шийдвэрлэсэн хэрэг дээр манай байгууллагаас хуульч Д.Мөнхбүрэн, өмгөөлөгч Г.Даваахүү нар ажиллаж байна.
- Орхон аймгийн “Нар туссан цаг” сонины редакцид аймгийн Ардчилсан холбооноос мэдээллийн нууц эх сурвалж шаардсан албан бичиг ирүүлсэнд манай байгууллагаас эсэргүүцэж, байр сууриа илэрхийлж, сэтгүүлчдэд эрх зүйн зөвлөгөө өгөв. Манай зөвлөсний дагуу, редакцийн зүгээс тус холбооны албан бичигт хариу явуулж, мөн сонин дээрээ энэ асуудлаар байр сууриа илэрхийлсэн нийтлэл бичжээ. Ингэсний үр дүнд мэдээллийн нууц эх сурвалж шаардсан МоАХ-ноос үйлдлээ зогсоожээ.

Хавсралт 11. ГИ Төвөөс “Нар туссан цаг” сонинд өгсөн зөвлөгөө

- Сэтгүүлч А.Баттөр манай байгууллагад хандаж, эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн тусламж хүссэний дагуу Д.Мөнхбүрэн энэ хэрэг дээр ажиллаж, тухай бүрт эрх зүйн зөвлөгөө өгөх, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцагчтай биечлэн уулзах, сэтгүүлчид үүсгэсэн Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох албан захидал явуулсан. Үүний үр дүнд сэтгүүлчид холбогдох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоход нөлөөлсөн.
- Сэтгүүлч Эрдэнэцэцэгт 2013 оны 1-р сард Зам, тээврийн яамны газрын дарга Б.Жаргалын гомдлын Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр хэрэг үүсгэсэн. Энэ хэрэг дээр манай байгууллага мониторинг хийж, сэтгүүлчид тухай бүр эрх зүйн зөвлөгөө өгөн, шат шатны шүүх хуралд ажиглачаар оролцож байна. Сүхбаатар дүүргийн шүүхэд 2013 оны 6 сарын 21-нд болсон анхан шатны шүүх хурлаар сэтгүүлчтэй холбоотой хэргийг цагаатгасан. Анхан шатны шүүх хуралд Глоб Интернэшнл Төвийн хуульч Мөнхбүрэн, хөтөлбөрийн зохицуулагч Аюушжав нар мониторинг хийсэн. Шүүх хурлыг явуулсан шүүгч Г.Билгүүн нь 2012 оны 9-р сард манай байгууллагаас АНУ-ын ахмад хуульчдийн төсөлтэй хамтран зохион байгуулсан сургалтад оролцож байсан. Шүүгч шийдвэр гаргахдаа сэтгүүлчийн хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг, мөн олон улсын зарчмуудаас дурдсаныг манай ажилтнууд тэмдэглэв. Шүүгч шударга шийдвэр гаргаж, олон улсын хэм хэмжээг шүүхийн практикт хэрэглэж буй нь сайшаалтай хэрэг.

3.3. Глоб Интернэшнл Төвийн үйлдэл

3.3.1. Шуурхай мэдээ

Глоб Интернэшнл Төв “Тэргүүн” сонины сэтгүүлчдийг Эрүүгийн хэргээр ял тулгаж, шат шатны шүүхээс сэтгүүлчдийг шоронд хорихоор айлган сүрдүүлж дарамт учруулсан, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дампуурахад хүргэж болзошгүй их хэмжээний торгууль ногдуулсныг эсэргүүцэж, шуурхай мэдээ түгээв. Шуурхай мэдээг байгууллыгн цахим хуудса, фейсбүүк хуудас болон дотоод сүлжээгээр түгээж, мөн дэлхийн 90 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн чөлөөт илэрхийллийн олон улсын сүлжээ IFEX байгууллага руу явуулав.

<http://globeinter.org.mn/?cmd=Record&id=1069&menuid=366>

<https://www.facebook.com/GlobeInternational>

http://www.ifex.org/mongolia/2014/01/14/tergun_newspaper/

Хавсралт 12. ГИ Төвөөс “Тэргүүн” сонины 3 сэтгүүлчид Эрүүгийн хэргээр ял тулгасныг эсэргүүцэж, түгээсэн шуурхай мэдээ монгол, англи хэл дээр

3.3.2. Эсэргүүцлийн захидал, албан захидал

- Глоб Интернэшнл Төв Ерөнхий сайд Н.Алтанхуягт хандаж, “Тэргүүн” сонины сэтгүүлчдэд Эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр гомдол гаргасныг эсэргүүцэж, захидал явуулав. Захидалдаа Ерөнхий сайдыг иргэний хувьд өөрийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд хүссэн хэлбэрээр хариу өгөх эрхтэй ба нэр төрөө хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлүүлэх

боломжтойг сануулаад, хэргээ ухаалгаар шийдэх нь олон улсын тавцан дээр Монгол улсын Засгийн газрын хүндэд эерэгээр нөлөөлнө хэмээн байр сууриа илэрхийлэв.

Хавсралт 13. ГИ Төвөөс “Тэргүүн” сонины сэтгүүлчдэд холбогдох Эрүүгийн хэргийн талаар Ерөнхий сайд Н.Алтанхуягт хандаж илгээсэн албан захидал

- Глоб Интернэшнл Төв Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч Д.Сайнжаргалд сэтгүүлч А.Баттөрд холбогдох Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай албан захидал явуулав. Захидалдаа мэдээллийн эх сурвалж нь өөр этгээд байгаа, мөн нүүрний ихнэх хэсгийг халхалсан эмэгтэйн хэн болохыг таних боломжгүй, сэтгүүлч өөрөө залруулга хийсэн зэргийг харгалзан, хэргийг хэрэгсэхгүй болгож, шаардлагатай бол шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлт тавив.

3.4. Орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт

Төслийн үйл ажиллагааны хүрээнд тус төвөөс 2013 оны 10-р сарын 28-нд “Бишрэлт” зочид буудлын сургалтын танхимд орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт зохион байгуулав. Уг сургалтад Орхон, Дархан, Булган, Өмнөговь, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг болон УБ хотын ХМБ-ын 11 хуульч, өмгөөлөгч хамрагдав.

*Хавсралт 14. Сургалтын хөтөлбөр монгол, англи хэл дээр
Хавсралт 15. Сургалтад оролцогчдын жагсаалт*

Төслийн дагуу өмгөөлөгчдийг 2 хоногийн сургалтад хамруулах байсан ч бид төлөвлөгөөндөө бага зэрэг өөрчлөлт оруулж, манай байгууллагаас 2013 оны 10 сарын 29-30-ний өдрүүдэд зохион байгуулах Хэвлэл мэдээллийн үндэсний бага хуралд орон нутгийн дээрх хуульч, өмгөөлөгчдийг хамруулахаар шийдэв. Тус бага хурлаар Монголын хэвлэл мэдээллийн хөгжлийн өнөөгийн байдалд ЮНЕСКО-гийн Хэвлэл мэдээллийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хийсэн судалгааны тайланг хэлэлцэж, тал бүрийн санал, дүгнэлтийг тусган, мөн Засгийн газарт хүлээлгэн өгөх зөвлөмжийн төслийг хамтран боловсруулав. Орон нутгийн өмгөөлөгчдийн сургалтад хамрагдсан манай 11 хуульч, өмгөөлөгчид дээрх судалгааны “Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин” хэсэг дээр ажиллаж, хэвлэл мэдээллийн өнөөгийн байдлын талаарх мэдлэг, ойлголтоо дээшлүүлж, тухайн ангиллын зөвлөмж боловсруулахад өөрсдийн хувь нэмрээ оруулсан юм.

Сургалтад Глоб Интернэшнл Төвийн 3 сургагч багш болон АНУ-ын Ахмад хуульчдын төслийн хуульч Дэниэл Байрон нар илтгэл тавьж, монголын хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн байдал, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын хэм хэмжээ, мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах, гүтгэлэг доромжлолын хэргийг Эрүүгийн хэргээр шийдвэрлэхийн сөрөг талууд, дотоодын хууль тогтоомжид тусгасан хэвлэл мэдээлэлтэй холбоотой зүйл заалт, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийг өмгөөлөх онцлог тактик зэрэг сэдвээр оролцогчдын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэв.



АНУ-ын Ахмад хуульчдийн төсөл нь манай байгууллагатай монголын хэвлэл мэдээллийн эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр хамтран ажилладаг бөгөөд 2012 оноос эхлэн жил бүр тус төслийн ахмад хуульч ирж, эрх нь зөрчигдсөн сэтгүүлчдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, их, дээд сургуулиудад лекц унших, өмгөөлөгч, хуульчдад сургалт зохион байгуулах, хуулийн төсөл дээр санал бодлоо илэрхийлэх зэргээр хамтран ажилладаг.

Сургалтыг илүү дадлагад суурилсан хэлбэрээр, урьд өмнө шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийг задлан шинжлэх хэлбэрээр явуулсан бөгөөд дараах илтгэлүүд тавигдав:

- “Үзэл бодлын эрх чөлөө ба түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө”, Х.Наранжаргал, Глоб Интернэшнл Төвийн тэргүүн

Хавсралт 16

- “Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин”, Д.Мөнхбүрэн, Глоб Интернэшнл Төвийн хуульч

Хавсралт 17

- “Төрийн байгууллагын ил тод байдал ба мэдээлэл олж авах эрх”, Х.Наранцэцэг, Глоб Интернэшнл Төвийн хөтөлбөрийн зохицуулагч

Хавсралт 18

- “Түтгэлэг: АНУ-ын болон олон улсын хууль”, АНУ-ын хуульч Дэниэл Байрон
- “Өмгөөллийн онцлог. Анхаарах асуудлууд”, АНУ-ын хуульч Дэниэл Байрон
- “Цахим хуудасны зохицуулалтын асуудал”, АНУ-ын хуульч Дэниэл Байрон

Хавсралт 19: АНУ-ын хуульч Дэниэл Байроны тухай танилцуулга, илтгэлүүд

Сургалтын үр дүнд:

- орон нутгийн өмгөөлөгчид хэвлэл мэдээллийн эрх зүйн орчны талаарх ойлголт мэдлэгээ дээшлүүлж, тухайн аймагт мэргэжлийн эрхийн зөрчилтэй тулгарсан

сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өмгөөллийн туслалцаа үзүүлэх чадвартай болов.

- орон нутгийн өмгөөлөгчид шүүхийн практикт Хүний эрхийн түгээмэл тунхаглал, ИУТЭХОУП-ын 19-р зүйл, сэтгүүл зүйн олон улсын зөөлөн хэм хэмжээ, 19-р зүйлийн тайлбар зэрэг олон улсын хэм хэмжээг шүүхийн практикт хэрэглэх чадвартай болов.
- сургалтад хамрагдсан орон нутгийн өмгөөлөгчид өөрийн өмгөөлж буй хэргийн талаар манай байгууллагын болон туршлагатай өмгөөлөгчидтэй онлайнаар зөвлөлдөх болов.
- мөн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой дор хаяж нэг хэрэг дээр ажиллан, үнэлгээ хийлгэх тохиролцоонд хүрэв.

V. Төслийн үнэлгээ

5.1. Үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ

Төлөвлөгөөт үйл ажиллагаа	Үзүүлэлт	Үр дүн	Хэмжүүр
1. Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бүртгэл	<i># бүртгэсэн мэргэжлийн эрхийн зөрчил</i>	Төслийн тайлант хугацаанд 10 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой мэргэжлийн эрхийн 11 зөрчлийн тохиолдол бүртгэж, үүнээс 7 сэтгүүлчид эрх зүйн зөвлөгөө өгч, өмгөөллийн туслалцаа үзүүлэв.	Зөвлөгөө авсан сэтгүүлч, ХМБ-ын тоо Үр дүнд хүрсэн хэргийн тоо
2. Эрх зүйн зөвлөгөө	<i># эрх зүйн зөвлөгөө авсан сэтгүүлч, ХМБ-ын тоо # өмгөөллийн туслалцаа авсан сэтгүүлч, ХМБ-ын тоо</i>	Мэргэжлийн эрх нь зөрчигдсөн 7 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад эрх зүйн зөвлөгөө өгч, 1 сэтгүүлчийн хэрэг дээр мониторинг хийж, шат шатны шүүх хуралд ажиглагчаар оролцон, 1 сэтгүүлчид стратегийн өмгөөлөл үзүүлэх төсөл боловсруулж, батлуулав. Орхон аймгийн сониноос нууц эх сурвалж шаардах дарамт зогссон.	МҮОНТ-ийн сэтгүүлч М.Бямбасүрэнгэй хамтран “цагаан будааны дээжийг шинжлэх” төслийн ННФ дэмжиж, хэд хэдэн ТББ-ууд хэрэгжүүлж байна. Глобын илгээсэн зөвлөгөө
3. Глоб Интернэшнл Төвийн үйлдэл	<i># шуурхай мэдээний тоо # эсэргүүцлийн захидлын тоо</i>	“Тэргүүн” сонины 3 сэтгүүлчдэд Эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхээс тэдэнд хэт өндөр торгууль	Цахим хуудас: http://globeinter.org.mn/?cmd=Record&id=1069&menuid=366

	# албан захидал, хүсэлтийн тоо	<p>ногдуулсныг эсэргүүцэж шуурхай мэдээ түгээв.</p> <p>Англи хэл дээрх мэдээ олон улсын сүлжээгээр түгээв.</p> <p>Дээрх хэргийг үүсгүүлэхээр гомдол гаргасан ЕС Н.Алтанхуягт хэргээ хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэхийг зөвлөж, албан захидал илгээв. ЕС-ын өмгөөлөгч, ЗГХЭГ-ын Хуулийн хэлтсийн дарга Н.Энхтуяа тэргүүн Х.Наранжаргалтай энэ асуудлаар уулзах хүсэлт тавив.</p> <p>Сэтгүүлч А.Баттөрд үүсгэсэн Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай дүүргийн цагдаагийн хэлтэст 1 албан хүсэлт илгэсний үр дүнд сэтгүүлчид Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгов.</p>	<p>https://www.facebook.com/GlobeInternational</p> <p>http://www.ifex.org/mongolia/2014/01/14/tegun_newspaper/</p> <p>Шуурхай мэдээ монгол, англи хэл дээр</p> <p>Албан захидлын хувь</p>
4. Өмгөөлөгчдөд зориулсан сургалт	# оролцсон өмгөөлөгчдийн тоо # сургагч багш нарын тоо # тавигдсан илтгэлийн тоо # заагдсан сэдвийн тоо # АНУ-ын ахмад хуульчийн заасан сэдврийн тоо	2013 оны 10-р сарын 28-нд “Бишрэлт” зочид буудлын сургалтын танхимд орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт зохион байгуулав. Уг сургалтад Орхон, Дархан, Булган, Өмнөговь, Хөвсгөл, Сэлэнгэ аймаг болон УБ хотын ХМБ-ын 11 хуульч, өмгөөлөгч хамрагдав.	<p>Сургалтын хөтөлбөр</p> <p>Оролцогчдын жагсаалт</p> <p>Сургалтын материал</p> <p>Тавигдсан илтгэлүүд</p> <p>АНУ-ын ахмад хуульч Дэниэл Байроны CV, сургалтын материал англи, монгол хэл дээр /Хавсралтад/</p> <p>Сургалтын үеэр авсан гэрэл зураг</p>

--	--	--	--

VI. Асуудал, бэрхшээл

Төсөл хэрэгжүүлэх явцад дараах асуудлууд тулгамдав. Үүнд:

- Сэтгүүлчид өөрсдөд тохиолдож буй мэргэжлийн эрхийнхээ зөрчлийг олон нийтэд дэлгэх хүсэлгүй байдаг, өөрийн цензурт автсан, цаашдын дарамтаас айж, эмээдэг болох нь ажиглагдсан.
- Дээрх асуудлуудаас үүдэж, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчлийн бодит тоо, баримт гаргах боломжгүй, ихэнх хэргүүд нуугдмал болж өнгөрдөг, сэтгүүлчид ч энэ байдлыг хэвийн зүйл мэт хүлээж авах нь элбэг.
- Сэтгүүлчид, ялангуяа орон нутгийн сэтгүүлчид хэт улс төржсөн, нам, эвслийн талд захиалгаар үйлчилдэг байдал газар авсаар байна.
- Сэтгүүлчид хэт бэлэнчлэх сэтгэлгээн автаж, бусдын мэдээ, материалыг хуулбарладгаас өөрсдөө асуудалд орж байна.
- Сэтгүүлчид зөвхөн нэг эх сурвалж дээр үндэслэх, эх сурвалжийн өгсөн мэдээллийг баталгаажуулах тал дээр дутмаг ажилладгаас эрх нь зөрчигдөхөд хүрдэг.
- Сэтгүүлчид, хэдийгээр манай байгууллагаас удаа дараа өөрөө шуурхай мэдээлэх системийн талаар сурталчилж, гарын авлага, сурталчилгааны хуудас тараах, сургалт бүр дээр энэ системийг танилцуулсан тусгай илтгэл тавих зэргээр ажиллаж байгаа боловч системд холбогдох сэтгүүлчдийн тоо хязгаарлагдмал байна. Тэд сүүлийн үед өргөн тархаад байгаа нийгмийн сүлжээг ашиглан, бидэнтэй холбогдох, мөн утсаар буюу биечлэн уулзахыг илүүд үзэж байна.
- Хэдийгээр манайд хандсан сэтгүүлч бүрт эрх зүйн зөвлөгөө өгч, эрхийг нь хамгаалах талаар алхамууд хийж байгаа боловч шүүхийн шатан дээр өмгөөллийн туслалцаа үзүүлэх боломжгүй байдаг. Манайд мэргэжлийн өмгөөлөгч байхгүй, гаднаас өмгөөлөгч хөлслөх нь хэт өндөр төлбөр шаарддаг зэргээс үүдэн, бид өмгөөллийн туслалцаа хүссэн сэтгүүлчдэд тэр бүр тусалж чаддаггүй.

VII. Дүгнэлт

Манай байгууллагын бүртгэснээр, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, дарамт шахалт үзүүлэх, сэтгүүлчдийг айлгах, утсаар заналхийлэх, дарамтлах, мэдээлэл олж авах, түгээхэд нь саад хийх, нууц эх сурвалжаа илчлэхийг албадах, улс төрч, төрийн өндөр албан тушаалтанууд Иргэний болон Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дуу хоолойг боомилох зорилгоор ашиглах зэрэг зөрчил буурахгүй байна. Мөн шүүх, цагдаагийн байгууллагаас сэтгүүлчдийг дарамтлах, эрх мэдэлтэй талд илтэд үйлчлэх зэрэг явдлууд гарсаар байна. Сэтгүүлчдийг мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд учирч байгаа аливаа дарамт, бэрхшээлийг бага гэлтгүй мэдээлж байх нь өөрийнхөө болон мэргэжил нэгтнүүдийнхээ эрхийг хамгаалахд хувь нэмэр оруулахыг сэтгүүлчдэд цаг ямагт ойлгуулж, сурталчилж байх шаардлагатай. Мөн тэдний ихэнх цагаа өнгөрөөдөг нийгмийн сүлжээгээр дамжуулан,

сүлжээ нээх, бүлэг бий болгох, мэдээ, мэдээлэл түгээх ажлыг эрчимтэй явуулах нь зөв алхам болоод байна. Ийм үүднээс бид, байгууллагын нийгмийн сүлжээг идэвхжүүлэх ажил хийж байна. Харин орон нутгийн сэтгүүлчид тэр бүр интернэтэд орох боломж байдаггүй, дөнгөж ашиглаж сурч байгааг харгалзан, орон нутгийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын жагсаалтыг аймаг тус бүрээр гарган, үе үе гар утсаар холбогдож, мэргэжлийн эрхийн зөрчил тохиосон эсэхийг лавлаж байх нь зүйтэй гэдэг дүгнэлтэд хүрэв.

Орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт зохиох үр дүнгээ өгнө гэдэгт итгэлтэй байна. Манай байгууллагаас 2012 оны 9 сард АНУ-ын ахмад хуульчдийн төсөлтэй хамтран, дүүрэг болон нийслэлийн шүүхийн шүүгчдэд сургалт зохион байгуулсан юм. Уг сургалт зохиох үр дүнгээ өгч, “Өдрийн шуудан” сонины сэтгүүлч Ц.Эрдэнэцэцэгийн хэргийн шүүх хурал дээр манай сургалтад оролцсон шүүгч Г.Билгүүн эрх мэдэлтэй талд үйлчлэлгүй, сэтгүүлчийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх, мөн олон улсын хэм хэмжээний талаар шүүх хурал дээр дурдаж, сэтгүүлчийг цагаатгасан нь талархуштай.

VIII. Санхүүгийн тайлан

МОНГОЛЫН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ХҮРЭЭЛЭН

Маягт #12

САНХҮҮЖИЛТ ОЛГОХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Овог нэр: Хашхүү Наранжаргал

Төслийн нэр: "Хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих нь. Хэвлэлийн эрх чөлөөний мониторинг"

Байгууллага: "Глоб Интернэшнл төв" ТББ

Гэрээний дугаар: 729

	Мөнгөний дүн ам.доллар	Төлбөр хийгдсэн огноо	Тайлан хийгдэх огноо
Гэрээнд заасан нийт санхүүжилт	12813200		2012.01.01 - 2014.12.30
Одоог хүртэл олгогдсон мөнгөний дүн			
1. Санхүүжилт	6569780	2013.01.17	2013.01.01 - 2013.06.30
2. Санхүүжилт	4569780	2013.11.12	2013.06.30 - 2014.01.01
3. Санхүүжилт			2014.01.01 - 2014.06.30
Үлдэгдэл мөнгөний дүн			
Энэ удаагийн санхүүжилтийн хэмжээ	1673640		2014.01.01 - 2014.06.30

1. Төлбөр хүлээн авагч:	Банкны нэр:	Дансны дугаар #	Мөнгөний дүн:
а) "Глоб Интернэшнл төв" ТББ	ХХБ	499135163 /MNT/	4569780 MNT
б) "Глоб Интернэшнл төв" ТББ	ХХБ-804	404050566 /USD/	
в)			
г)			
д)			


2. Урьд олгогдсон санхүүжилтийн үйл ажиллагааны талаар бичнэ үү?

Орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалт
Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудад эрх зүйн зөвлөгөө өгөх
Сэтгүүлчдийн эрхийн зөрчилд мониторинг хийх

3. Энэ удаагийн санхүүжилтээр явуулах үйл ажиллагааныхаа талаар бичнэ үү?

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудад эрх зүйн зөвлөгөө өгөх
Сэтгүүлчдийн эрхийн зөрчилд мониторинг хийх

4. Хавсаргасан баримтууд (гурвадугч этгээдэд мөнгө шилжүүлж буй үед нэхэмжлэх хавсргана уу?)

Өргөдөл гаргалгачийн гарын үсэг:  (Ж. Энхжаргал)
(Х. Наранжаргал) Он сар өдөр

Өргөдөл хүлээн авагчийн гарын үсэг:  Он сар өдөр

5. Холбогдох тайлан өгсөн эсэх? Тийм Үгүй Боломжгүй

а) Үйл ажиллагааны тайлан  Хөтөлбөр зохицуулагч

б) Санхүүгийн тайлан Санхүүгийн тайлан

Л.Цэдэвсүрэн “Тэргүүн” сонины 2012 оны 05 дугаар сар. №19 /348/ дугаарт “Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлзөж байна”

Аймгийн шүүгчид даргынхаа ногоо цагааг тарьж сууж байхад энд зальт этгээдүүд л завшдаг бололтой. Олон хүнийг залилсан хэрэгт холбогдсон Ё.Уранчимэг гэгчийн хэргийг Алтангадас прокурор хэрэгсэхгүй болгож, улмаар гадаад руу оргон зайлах боломж олгожээ. Мөн “Капитал” банкны Орхон дахь салбарын захирал асан Баасандорж гэгч нөхөр залилан, албан тушаалын гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан гэнэ. Аймгийн засаг даргын орлогч Пүрэвхагвын дүү Баасандорж гэгчийн хэргийг давж заалдах шатны хуралдаанаар П.Батсайхан хэрэгсэхгүй болгож тэр хооронд Баасандорж нь мөн л оргон зайлжээ. Гэмгүй зугтаана гэж байхгүй. Тиймээс шүүгч нар л түүнийг зугтаах боломж олгосон бололтой. Их хэмжээний хөрөнгө мөнгөний асуудалд холбогдсон Баасандорж хэдийнээ хил давж, Ойрхи дорнодод араб хүүхэнтэй зугаалж яваа гэдэг сураг сонсогдоод л алга болжээ.

Шүүх засаглалд шинэчлэл хийх гэж Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ард түмэндээ амласан нь үнэн. Харин тэр амлалт биелэгдэх нь юу л бол доо. Байдлаас ажиглахад манай ерөнхийлөгч өөрөөсөө давсан амлалт авсан шинжтэй. Шүүхийн шинэчлэлийг хийхэд дан ганц шүүгч нартайгаа үзэлцэх бус, прокурор цагдаатайгаа бас Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуультайгаа үзэлцэх нь чухал байгааг амьдрал харуулж байна. Өнөөдөр монгол орон авилгын ертөнц болсон мэт амтай болгон орилж “Авилга, хээл хахуульд автагдлаа” гэж бүгд шагшран гаслах боловч үнэндээ үүнийг өөрчилж чадахгүй байсаар л байна. Хамгийн харамсалтай нь “Монгол Улсын нэрийн өмнөөс” хууль уншдаг шүүгч нарын ёс зүйг өнөөдөр эргэж харахгүй бол болохгүй болсон бололтой.

Хохирогч хохирсоор байх уу?

Одоогоос хэдэн жилийн өмнө Онцгой байдлын сайд асан С.Отгонбаяр улсын хөрөнгө мөнгө идсэн, ашигласан гэмт хэрэгтнүүдийг шалгуулах хүсэлтээ хуулийнханд гаргасан ч манай шударгаараа зартай цагдаагийнхан өөрийг нь барьж хорьж, гэмт хэрэг тохож, бүр шүүхээр оруулаад ял сонгосон. Улс төрийн бохир тоглоомын гарт төрийн сайд хохирсон тухай энэ мэдээг олон нийт их л хачирхан хүлээж авч байлаа. Тэгвэл хохирогчийг гэмт хэрэгтэн болгож хувиргадаг, айлгаж дарамталдаг, аргагүй байдалд оруулж нэхэмжлэлийг нь татуулдаг арга хаа сайгүй л байдаг бололтой. Одоогоос олон жилийн өмнө Д.Дорлигжав Эрдэнэт Уулын баяжуулах үйлдвэрийн захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байхдаа тус үйлдвэрээс цомхтголоор халагдсан цэцэрлэгийн багш, өрх толгойлсон хэдэн эмэгтэйг амьдарч байсан байранд нь үлдээх шийдвэр гаргаж байжээ.

Гэтэл гэнэтхэн тус үйлдвэрийн захирлууд өрх толгойлсон хэдэн эмэгтэйг орон байрнаас нь хөөж, байж суух аргагүй болгожээ. Орох оронгүй болох дээрээ тулсан эмэгтэйчүүдийг төлөөлж, Мөнхтуяа гэгч бүсгүй өөрийнхөө эрх ашгийг хамгаалуулахаар Орхон аймгийн шүүхэд гомдол гаргасан гэнэ. Гэвч Орхон аймгийн орлогч прокурор асан одоо /Өвөрхангай аймагт ажиллаж байгаа / Алтангадас гэгч гомдол гаргасан нэхэмжлэгчийг хэрэгт татаж, эцэст нь ял хүртэл сонсгож, 28 сая төгрөгөөр торгуулаад салсан гэдэг мэдээлэл олон хүнийг цочирдуулж байна. Улсын яллагчийн гарт хүний хувь заяа бий.

Гэтэл Орхон аймгийн орлогч прокурор асан Алтангадас гэгч энэ эрийг хариуцагч Ё.Уранчимэг гэгчийг хамгаалахын тулд хохирогчийг гэмтэн болгосон хэмээн ярьцгааж байх юм. Харин яагаад Алтангадасын талаархи мэдээллийг хууль хяналтынханд гаргаж өгөөгүй юм бэ гэсэн асуултад тэд “Алтангадас өөрийгөө Хууль зүй дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Баясгалангийн төрсөн дүү гэж ярьдаг. Тиймээс гомдол гаргавал дахиад л хэрэгтэн болчихож магадгүй гэж айсан хэмээн тайлбарлаж байх юм.

Захирамжид гомдол гаргах эрхгүй гэнэ үү?

Монгол Улсын хуулийн дагуу хүн өөрийнхөө гомдлыг бүх шатны шүүхэд гаргах эрхтэй. Гэвч энэ хууль Орхон аймагт л үйлчилдэггүй юм байна. Орон байраа алдаж, үр хүүхдээ дагуулаад гудамжинд гарах дээрээ тулсан хэдэн бүсгүйчүүд сум дундын шүүхэд гомдол гаргасан гэнэ. Хамгийн хачирхалтай нь сум дундын шүүхийн ерөнхий шүүгч Ариунцэцэг “Та нар ингээд заргалдаарай” гэсэн шиг шүд зуусан шийдвэр гаргасан байдаг. Тэр шийдвэрт нь давж заалдах гэхээр хуульд байхгүй заалтыг иш болгон “Захирамжид гомдол гаргах эрхгүй” гэж нэхэмжлэгчийн давж заалдах эрхийг хязгаарласан байх юм. Ийм хуулийн заалт байдгийг мэдэх нэг ч хуульч олдсонгүй. Тэгэхээр Орхон аймагт арай өөр хууль үйлчилдэг бололтой. Энэ шийдвэрийн гайгаар өнөөдөр хэдэн эмэгтэй орох оронгүй, гэрэл цахилгааныг нь тасласнаас харанхуй өрөөнд үр хүүхэд нь хоол ундгүй, хичээл номоо ч хийж чадахгүй хүнд байдалтай өдөр хоногийг өнгөрөөж байна.

Олон сар дамнан шүүхийн хаалга татсан эмэгтэйчүүд ч цөхрөнгөө барж эхэлжээ. Бүх хууль, бүх хүн тэдний эсрэг босож эхэлжээ. Нэхэмжлэгч нар аймгийн шүүхэд гомдлоо гаргадаг. Гэвч хариуцагч болох Эрдэнэт үйлдвэрийг төлөөлж, аймгийн шүүхийн шүүгч П.Батсайханы гэргий Ганчимэг гэгч бүсгүй ороод ирдэг гэнэ. Даргынхаа эхнэрийг харсан шүүгчид шууд л нэхэмжлэгчдийн эсрэг нэгддэг тухай хохирогч нар ярьцгааж байна. Ер нь шүүгчдийн гэргий нар Эрдэнэтэд ирэхээрээ ГОК-д ажилд ордог. Эхнэр нь ажилладаг учраас яах аргагүй Эрдэнэт үйлдвэрийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргадаг нь аргагүй л байх.

Аймгийн шүүхийн дарга уу, албат хамжлагатай нударган баян уу?

Орхон-Уул аймгийн шүүхийн шүүгчдийн тухай тун хачирхалтай мэдээлэл чих дэлсэж байх юм. “Бурхангүй газрын бумба галзуурна” гэж орон нутгийн шүүхийн дарга болчихоор л “Намайг хэн хэлэхэв, нохойг хэн саахав” гэсэн юм шиг дураараа загнацгаадаг. Шүүхийнхээ хэдэн ажилчдыг өөрийн зарц, барлаг шиг л хувийн ажлаа хийлгэж ногоогоо тариулж, ар гэрийнхээ нүүдэл суудлыг хийлгэхээс аваад эхнэр хүүхдийг нь ажил сургуулиас нь зөөцгөөдөг аж. Бас Дархан, Улаанбаатар руу ачаа, бараа зөөлгөх гээд зарж байдгийг шүүхийн ажилчид төдийгүй аймаг даяар нэг үгээр Эрдэнэт хотынхон бүгд л мэднэ.

Ерөнхий шүүгч П.Батсайхан сум дундын шүүхийн болон давж заалдах шатны шүүх хуралдааны үйл явцад өөрийн эрх хэмжээндээ хяналт тавьж оролцох нь зүйн хэрэг боловч тэр үүргээ зөвхөн өөрийн амин хувьд хэрэгцээтэй үед санаж бусад цагт нь үндсэн ажлаа урсгалд нь орхиж, аминыхаа ажлыг өдөржин хөөцөлдөж албаныхаа ажлыг хойш тавьж явдаг гэнэ.

П.Батсайхан албаны мөнгөөр зуслангийн торхнууд худалдаж аваад өөртөө ашигласан. Зуслангийн байшингаа шүүхийн мэдлийн гэж ярих боловч өнөөдрийн байдлаар шүүхийн үндсэн хөрөнгөд бүртгэлгүй өчнөөн жил болох нь байна. Энэ хавраас хэдэн байшин барих сураг гарч байгаа хандив нэртэй хээл хахууль цэцэглүүлэх гэж байгаа. Бас П.Батсайхан

албаны юмыг амины юм шиг хэрэглэх нь бүүр аатай “шүүн таслах болон дотоод ажлын хэрэгцээ”-ний Аймаг сум дунд, захиргааны хэргийн шүүхийн дундын дуудлагын унаа болох 0006 дугаартай “веросса” маркийн авто машин мөн микро автобус зэрэг нь албан ажилд алдаг оног явдаг.

Ерөнхий шүүгчийн ар гэрийн унаа болсон бөгөөд гэрийнхэн нь гадаа уяатай хонодогийг хэн хүнгүй мэднэ. Хүүхэд нь Дархан нүүнэ л гэнэ нөгөө албаны машин жолооч Батгэрэл нярав Алтансүх хоёр үйлээ үзнэ. Тамгын газрын Ганчулуун даргын хүүхэд харанхуй шөнөөр албаны машин унаж яваад онхолдуулсаныг цагдаа шүүхгүй тас нуугаад өнгөрөөсөн байх юм.

“Шүүхийн ерөнхий зөвлөл” гэж нэг санаа амар газар байна. П.Батсайханы хувийнхаа ажлаар Дархан явуулсан “Тоёота веросса” маркийн авто машин эвдэрхэд засвар сэлбэгийн мөнгө 1650 ам долларыг гаргаад л өгч байх юм. Аргагүйдээ П.Батсайхан даргын амин хувийн хэрэгцээнд зарцуулсан машины түлш шатахууныг ямар өөрөөс нь гаргуулах биш нөгөө муу ядсан татвар төлөгчдийн халааснаас гаргуулах юм чинь. Тэгээд ч ганц Шүүхийн ерөнхий зөвлөл биш Орхон аймгийн Засаг даргын газар, “ГОК”-ийн захиргаа бүгд аймгийн шүүхээ дэмжиж байна гэсэн нэрийн дор мөнгө угааж зувчуулах нь хэвшил болсон бололтой. Үүний манлайд нь Засаг даргын орлогч Пүрэвлхагва “Эрдэнэт сан” гэгч төрийн сан юм уу, төрийн бус сан юм уу бүү мэд нэг байгууллагыг аймгийн санхүүгийн дарга, ерөнхий няглан бодогч байхдаа байгуулж амжсан.

Мөнгө идэх нэг сувгаа Аймгийн шүүх болгосон бөгөөд үүнийг аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга гардан эрхлэдэг гэнэ лээ. Аймгийн тамгын хэлтсийн даргын 2010 оны тавдугаар сарын 10-ны өдрийн 17 тоот тушаалыг харахад л болно. Энэ тушаалаар 1 сая 450 мянган төгрөгийг шүүгч ажилтан нарт тусламж олгосон байх юм. Гэтэл энэ мөнгөнөөс тусламж хүртсэн хүн нэгээхэн ч байхгүй нь хачирхалтай. Мөнгө хаачсаныг мухарлаад үзвэл тамгын газрын дарга, ерөнхий шүүгч хоёр маань завшиж уг мөнгөнөөс нь хэрэглэж тамгын газрын дарга Архангай явсан байдаг. Ингээд тоочоод байвал их зүйл байх юм. Орхон аймаг төдийгүй Дархан-Уул, Сэлэнгэ зэрэг аймгуудын хуулийн байгууллагын дарга ажилтнууд ч гэсэн ялгаагүй ууж идэхийн уут болтолоо ялзарсаныг ухаж гаргах зоригтон олдох болов уу.

Л.Цэдэвсүрэн

Ерөнхий сайдын охин ”мэргэжлийн” покерчин

Сайдын сэнтийд тухлаад тун ч удаагүй байгаа АН-ын дарга Н.Алтанхуягийн хувийн амьдрал, хуучин шинэ эхнэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр багагүй шуугидаг. Тиймдээ ч эрхэм сайдын хэрхэн шар сэмжилсэн, сэмжлээгүй талаар манай уншигчид бараг “мастер”-ын зэрэгтэй мэдэх болсон биз. Бүр бага эхнэр нь түүнд хүү төрүүлж өгсөн, өгөөгүй талаар маргадаг хэр нь том охин А.Намууных нь талаар тэр бүр яриад байдаггүй нь сонин.

Шинэхэн сайдын маань анхны эхнэрийг оюутан сурагч, ойр дотныхон нь тун ч даруухан, сайхан эмэгтэй хэмээн магтдаг бол түүний охин А.Намуунааг Монголд тун цөөхөн байдаг покерын мэргэжлийн диллерүүдийн нэг гэдгийг мэдэх хүн ховор байх. Тэр ч бүү хэл сайдтаны гүнжтэнг ойр тойрныхон, найз нөхөд нь хүртэл улаан покерчин, бүр багагүй донтчихсон нэгэн гэж огт тааварладаггүй юм билээ. Харин А.Намуунаа үүнийгээ ердөө “хобби” төдийхөн хэмээдэг.

Мэдээжийн хэрэг мэргэжлийн покерчин бүсгүйд мурий тавих их хэмжээний мөнгө хэрэг болдог нь нууц биш. Тийм ч болохоор А.Намуунаа гэр бүлийн хүрээндэх жижигхэн бизнесээ тун ч давгүй авч явдаг юм билээ. Ээж нь МУИС-ийн багш, аав нь МУ-ын ерөнхий сайд гэхэд тун ч сонирхолтой хоббитой эмэгтэй юм гэмээр байвч үнэндээ тийм болохоороо л бүүр ийм содон сонирхолтой байдаг ч юм билүү. Ямартай ч энэ бүхэн нь Н.Алтанхуяг даргын амин охины “хобби” төдийхөн. Харин дэлхий дахинд мурийтай тоглоомын донтон, ер нь ямар нэгэн зүйлийн донтон л бол “донтон” л байдаг нь нууц биш.

Б.Отгонжаргал

Хавсралт 2

Сэтгүүлчдийн гомдол

Тэргүүн сонины 2012 рны тавдугаар сард сэтгүүлч Л.Цэдэвсүрэнгийн бичсэн “Эрдэнэтийн шүүгч нар Ерөнхий шүүгчийнхээ зарц барлаг шиг амьдарч байна нийтлэл, Мөн тус сонины 2013 оны наймдугаар сард сэтгүүлч Б.Отгонжаргалын бичсэн “Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин” гарчигтай мэдээ гарсан юм. Энэ дагуу Эрдэнэтийн Ерөнхий шүүгч П.Батсайхан, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нар Чингэлтэй дүүргийн цагдаад гомдол гаргаж, уг мэдээллүүдийг бичсэн Л.Цэдэвсүрэн, Б.Отгонжаргал, Тэргүүн сонины ерөнхий эрхлэгч Б.Цоожчулуунцэцэг нарт эрүүгийн хэрэг үүсгэн бүтэн жил шалгуулсны эцэст Чингэлтэй дүүргийн шүүхээр тэдэнд торгуулийн ял оноогоод байна. Чингэлтэй дүүргийн шүүхээр 2013 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хянан хэлэлцээд шүүгдэгч Б.Отгонжаргалд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял, шүүгдэгч Л.Цэдэвсүрэнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 55 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял, Б.Цоожчулуунцэцэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

Хавтаст хэрэгт цугларсан баримт материалыг харахад:

1. Мөрдөн байцаагч Ганзориг нь Иргэний бүртгэлийн Ерөнхий газраас лавлагаа авсан бөгөөд энэ лавлагаагаар нэхэмжлэгч Н.Алтанхуягийг Ганчимэг гэдэг эхнэртэй гэж тодорхойлж, сэтгүүлчийг буруутгах гол баримт болгож байгаа юм. Гэтэл албан болон албаны бүхий л эх сурвалжид Н.Алтанхуягийг Х.Сэлэнгээ гэдэг эхнэртэй гэж бичсэн байна. Тиймээс хуурамч нотлох баримтаар сэтгүүлчийг буруутгаж байгаа гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Тиймээс **Эрүүгийн хуулийн 253.2.-т зааснаар Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлж, ял шийтгэл оноох гэж байна гэж үзэж байна. /Нотлох баримтуудыг ард хавсаргав./**

2. Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулах **Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 21.2. –аар зүйл ангийг эрс зөрчиж, нэхэмжлэгч, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягт ашигтайгаар хавтаст хэргийг бүрдүүлсэн байна.** Үүнийг мэдээллийн эх сурвалж, гэрчүүдийг дутуу байцаасан, мэдээлэл өгсөн хүнийг энэ хэрэгт ямар ч холбогдолгүйгээр орхисон. Өөрийгөө Н.Алтанхуягийн охин гэж нэрлэдэг Намуунаас зөвхөн гэрчийн мэдүүлэг аваад л өнгөрсөн зэргээс харж болно.

3. Сэтгүүлч Б.Отгонжаргал нь гэрч, мэдээллийн эх сурвалж, мөн мэдээлэл өгсөн хүнийг мөрдөн байцаалтын явцад мэдүүлсэн бөгөөд зөрүүтэй мэдээллүүдийг хянаж үзээгүй, нүүрэлдүүлэн байцаалт аваагүй байна.
4. Б.Цоожчулуунцэцэг намайг энэ хэрэгт буруутай гэж Прокурор үзсэн бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэж заасан дээрх хуулийн заалтыг үндэслэн надад эрүүгийн хэрэг үүсгэн, шалгаж байгаа нь нь хуулийн утга санааг буруу ойлгож хэрэглэсэн гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна. Учир нь дээрх нийтлэлүүдийг **Б.Отгонжаргал, Л.Цэдэвсүрэн нарын** сэжигтнээр татан, улмаар ял сонсгож яллагдагчаар татаж, Гэрч Даваагийн мэдүүлгийг ашиглан гэм буруутай нь тогтоогдож байна гэж бичжээ. Гэтэл Гэрч Даваа нь яллагдагч болчихоод байгаа Б.Отгонжаргалын төрсөн ах, бас энэ мэдээллийг хэвлэлд өгсөн хүн нь юм. Манай сонины үйл ажиллагааны талаар юу ч мэдэхгүй Даваагийн “Тэргүүн сонины эрхлэгч тэгж хэлсэн гэсэн” гэдэг үгээр гэм буруутай гэж үзсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна.
5. Сэтгүүлч Л.Цэдэвсүрэн нь өнөөдрийг хүртэл мэдээлэл өгсөн эх сурвалжаа нууцалж байгаа бөгөөд уг хэргийг хянасан прокурор, мөн мөрдөн байцаагч Ганзориг, шүүх хурлын үеэр шүүгч хүртэл “Чи эх сурвалжаа хэлж өгөөд энэ хэргээс мултар” гэж дарамт шахалт үзүүлж байлаа.
6. Энэ хэргийг шалгаж буй мөрдөн байцаагч намайг дуудаж мэдүүлэг авахдаа “Та нарын буянаар Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягаас мэдүүлэг авч үзлээ” хэмээн ярьж байсан бөгөөд мөрдөн байцаагч “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн 21.2-р зүйл ангийг эрс зөрчиж, нэхэмжлэгч, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг, шүүгч П.Батсайхан нарт ашигтайгаар хавтаст хэргийг бүрдүүлсэн байна.
7. Нэхэмжлэгч П.Батсайхан нь улсын өмч хөрөнгийг бүртгэлд оруулалгүйгээр хадгалсан, албаны машин унаж байгаад гэмтээсэн гэх мэт олон зүйл хавтаст хэрэгт нотлогдож байгаа ч үүнийг зөвхөн сэтгүүлчийн эсэрг баримт болгон ашигласан байна.
8. Мөрдөн шалгах явц бүхэл бүтэн жил гаруй хугацаанд үргэлжилж, хуулийн байгууллагыг хүндэтгэн, дуудсан цагт нь очдог сэтгүүлч нарыг залхаан цээрлүүлэх маягаар асуудалд хандаж, Чингэлтэй дүүргийн мөрдөн байцаагч Ганзориг нь төрөх гээд өвдөж байгаа бүсгүйг гараад ир “Хавтаст хэрэгтэйгээ танилц” хэмээн тохуурхаж, төрөөд дөнгөж хэдхэн хонож байгаа хүнд хавтаст хэрэг аваачиж өгөн орцонд гарын үсэг зуруулж, бүтэн жил тун сайн ажиллаа. Гэхдээ мөрдөн байцаагч мэдээллийн эх сурвалж, гэрчүүдийг дутуу байцаасан, мэдээлэл өгсөн хүнийг энэ хэрэгт ямар ч холбогдолгүйгээр орхисон байна.
9. Шүүхийн шийдвэр гарсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг нь Би улстөрд ороод 23 жил болж байна. Энэ хугацаанд сэтгүүлчийг шүүхэд өгсөн түүх байхгүй. Харин сэтгүүлчийг урдаа барьж захиалгатай юм бичүүлчихээд, хариуцлагаа хүлээхгүй ард нь үлддэг байгууллагыг шүүхэд өгсөн удаа бий. Гүтгэлгийн чанартай мэдээлэл гарахад би "Өглөө" кинонд гардаг шиг "Эзэн нь хэн бэ" гэж асуудаг. Гүтгэлгийн мэдээ тарааж байгаа бол тухайн редакци, эзэн нь хариуцлагаа хүлээж сурах хэрэгтэй” хэмээн сонин хэвлэлийг гүтгшэлгийн мэдээг захиалгаар бичүүлж тараадаг гэсэн тайлбарыг улс орон даяар цацаж, хэвлэл мэдээллийн нэр хүндэд халдсанд гомдолтой байна.
10. Тэргүүн сонины удирдлагын зүгээс сэтгүүлч нарт Н.Алтанхуягийн талаар мэдээ бичих үүрэг өгөөгүй. Ямар нэгэн байдлаар албандан бичүүлээгүй гэдэг нь мөрдөн байцаалтын явцад тогтоогдсон юм.
11. Гурван сэтгүүлчид эрүүгийн хуулийн дагуу ял сонсгосны дараа Н.Алтанхуяг сэтгүүлч нарт “хайр” зарлаж нэр бүхий хэвлэлүүдтэй гэрээ байгуулна хэмээн төлөөлөгч нараараа дамжуулан мэдээлж, хэвлэлийн эрх чөлөөнд мөн л халдсаар байна. Түүнийг хэвлэлийг хуулийн байгууллагаар дамжуулан дарамталж, мөн сэтгүүлчдийг худалдан авч, нэгийг нь нөгөөгөөр нь дарах бохир арга хэрэглэж байна гэж үзэж байгаа юм.

12. Б.Цоожчулуунцэцэг миний бие 2012 онд Тэргүүн сонинг “Соёмбо принт” ХХК нэртэй хэвлэлийн компаниас худалдаж авсан бөгөөд энэ сонины ард ямар нэг улс төрийн эрх ашиг, сонирхол байхгүй. Гэтэл тус сонинг Ардын намын гишүүдийн сонин хэмээн үзэж, хэвлэлийн эрх чөлөөнд халдаж байгаад харамсаж байна.

13. Бид шүүх хурлаас өмнө хэвлэлийн бага хурал хийж, хавтаст хэрэгт цугларсан нотлох баримт, Н.Алтанхуяг гэдэг хүний хувийн амьдралтай холбоотой асуудлуудыг дэлгэж гаргахыг хүсэж байсан ч асуудалд буурь суурьтай хандахаар шийдсэн юм. Учир нь Н.Алтанхуяг Ерөнхий сайд албан болон албан бус эхнэртэй. Улсын бүртгэлийн газарт тэрбээр Ганчимэг гэдэг эхнэртэй гэж бүртгэгдсэн байдаг. Харин өөрөө Х.Сэлэнгээ гэгч бүсгүйг байнга өөрийн эхнэр гэж танилцуулдаг.

14. Яг шүүх хурлын өмнө тэрбээр албан бус эхнэрээ дагуулан Японд айлчлал хийсэн бөгөөд Төрийн өндөр дээд албан тушаалтны айлчлалын өмнө түүний гэр бүлийн талаархи мэдээллийг дэлгэж, сэтгүүлч нартай заргалдаж байгаа тухай хэвлэлийн бага хурал хийх нь улс орны нэр хүндэд халгаатай гэж үзсэн юм.

15. Энэ бүх баримтаас харахад Н.Алтанхуяг сайд нь хоёр эхнэртэй Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийг зөрчсөн гэдэг нь тодорхой харагдаж байна.

16. Гэтэл шүүгч нар энэ нотлох баримтыг авч хэлэлцэлгүйгээр сэтгүүлчийг буруутгаж байгаад харамсаж байна.



ШИЙТГЭХ ТОГТООЛ

2013 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 304

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн эрүүгийн шүүх хуралдааныг шүүгч Б.Зориг даргалж, шүүгч Г.Буяннэмэх, Г.Есөн-Эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй,

шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Ариунжаргал, улсын яллагч А.Дэлгэрмөнх, шүүгдэгч Б.Отгонжаргалын өмгөөлөгч Ч.Баднайнямбуу, шүүгдэгч Л.Цэдэвсүрэнгийн өмгөөлөгч Б.Энх-Эрдэнэ, шүүгдэгч Б.Цоожчулуунцэцэгийн өмгөөлөгч Б.Жамбал, хохирогч П.Батсайханы өмгөөлөгч Т.Мөнхтуяа, иргэдийн төлөөлөгч П.Цэрэнчимэг, Ж.Цогоо, Д.Хоролдулам нарыг оролцуулан тус шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар,

Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн Б.Отгонжаргал нарт холбогдох эрүүгийн 201201050898 дугаар хэргийг 2013 оны 8 дугаар сарын 9-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, 1989 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Завхан аймгийн Улиастай суманд төрсөн, 24 настай, эмэгтэй, дээд боловсролтой, сэтгүүлч мэргэжилтэй, эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл 6, эцэг, эх, эгчийн хамт Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо 16 дугаар хороолол Данзангийн 29-30 тоотод оршин суух, улсаас авсан гавъяа шагналгүй, ял шийтгэлгүй, ИЮ89012786 дугаар регистртэй, Барга овогт Болдын Отгонжаргал;

2. Монгол Улсын иргэн, 1984 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Увс аймгийн Улаангом суманд төрсөн, 29 настай, эмэгтэй, дээд боловсролтой, сэтгүүлч, эрхзүйч мэргэжилтэй, ам бүл 3, нөхөр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороо Цайз 5А-266А тоотод оршин суух, "Тэргүүн" сонины орлогч эрхлэгч ажилтай, улсаас авсан гавъяа шагналгүй, ял шийтгэлгүй, ОМ84062401 дүгээр регистртэй, Шаавай овогт Лхамжавын Цэдэвсүрэн;

3. Монгол Улсын иргэн, 1978 оны 2 дугаар сарын 17-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн суманд төрсөн, 34 настай, эмэгтэй, дээд боловсролтой, сэтгүүлч мэргэжилтэй, ам бүл 6, нөхөр, 4 хүүхдийн хамт Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо 23-36 тоотод оршин суух, "Тэргүүн" сонины ерөнхий эрхлэгч ажилтай, улсаас авсан гавъяа шагналгүй, ял шийтгэлгүй, РЮ78021701 дүгээр регистртэй, Мэргэд овогт Баянмөнхийн Цоожчулуунцэцэг.

Холбогдсон хэргийн талаар /Яллах дүгнэлтэнд бичигдсэн байдлаар/

"Б.Отгонжаргал нь Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Тэргүүн" сонины 2012 оны 8 дугаар сар. №31 /360/ дугаарт

021230

"Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин" гэсэн нийтлэл гарган Н.Алтанхуягийн ажил хэргийн болон гэр бүлийн нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлэг олон нийтэд тараасан,

Л.Цэдэвсүрэн нь Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутагт үйл ажиллагаа явуулдаг "Тэргүүн" сонины 2012 оны 5 дугаар сар. №19 348 дугаарт "Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлдөж байна" гэсэн нийтлэл гарган Орхон аймгийн шүүхийн ерөнхий шүүгч П. Батсайханыг нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор, гүтгэлгийг олон нийтэд тараасан,

Б.Цоожчулуунцэцэг нь "Тэргүүн" сонины ерөнхий эрхлэгчээр ажиллаж байхдаа 2012 оны 8 дугаар сар. №31 /360/ дугаартай "Тэргүүн" сонины 5 дугаар нүүрт нийтлэгдсэн "Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин" гэсэн гарчигтай нийтлэлийг туршилтын хугацаанд тус сонинд ажиллаж байсан Б. Отгонжаргал бичсэнийг мөн "Тэргүүн" сонины 2012 оны 5 дугаар сар. №19 /348/ дугаарт сонины 6 дугаар нүүрт "Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлзөж байна" гэсэн нийтлэлийг тус сонины орлогч эрхлэгч ажилтай Л.Цэдэвсүрэн нь бичиж, дээрхи 2 нийтлэлийг нягталж шалгалгүйгээр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэж заасныг зөрчин, хэвлэн нийтэлж бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлгийг олон нийтэд тараасан" гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ НЬ:

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Отгонжаргал мэдүүлэхдээ: "Намайг Отгонжаргал гэдэг. Би Монгол Улсын Боловсролын их сургуулийг 2010 онд сэтгүүлч мэргэжлээр төгссөн. Төгсөөд мэргэжлээрээ ажиллаагүй. Ахынхаа ажилд тусалдаг байсан. 2012 оны 8 дугаар сард миний найз охин Тэргүүн сонинд ажилд орсон. Тухайн үед Цоожчулуунцэцэг эгч Үндэстэн.мн сайтыг хариуцан ажилладаг байсан юм. Тэр үед сэтгүүлч нар нь ажлаасаа гарчихсан байсан учраас админ буюу мэдээ оруулагч ажилд авах хэрэгтэй байна гэсэн. Найздаа ажил мэдэж байгаарай гэж хэлж байсан учраас найз маань надаас тэр ажилд орох уу гэж асуусан. Би мэдээ оруулагчаар ажилд орьё гээд туршилтын хугацаанд хэд хоног ажилласан. Би Тэргүүн сонины газар биш харин Үндэстэн.мн сайтад ажилд орсон. Туршилтын хугацаандаа 3 мэдээ бичиж эрхлэгчдээ шалгуулсан. Түүнээс нэг мэдээ нь Тэргүүн сонинд нийтлэгдсэнээр энэ хэрэг гарсан. Алтанхуяг гэдэг хүний охины нэр төрд нь халдах санаа зорилго надад байгаагүй. Гагцхүү нэг зорилго байсан нь мэргэжлээрээ өмнө нь би ажиллаж байгаагүй болохоор мэдээг иймэрхүү бичвэл ямар вэ гэж л шалгуулахаар өгсөн юм" гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Л.Цэдэвсүрэн мэдүүлэхдээ: "Би тэргүүн сонины газар 2011 онд анх ажилд орсон. Тухайн үед надтай ямар нэгэн хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй. Тэргүүн сонинд сэтгүүлчээр ажиллаж байсан. Би Орхон аймгийн шүүгчийн нэр төрийг нь гутаах зорилготойгоор мэдээ бичээгүй. Орхон аймгийн иргэд, зарим нэг хүмүүсээс ирсэн захидал болон өөрийн эрэн сурвалжлах сэтгүүлчийн хардах эрхээ ашиглаж мэдээгээ бичсэн. Тухайн мэдээгээ нийтлүүлэхдээ эрхлэгчдээ уншиж танилцуулсан. Мэдээг нийтлэх эсэх нь эрхлэгчийн л шийдвэрлэх асуудал байдаг юм" гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Цоожчулуунцэцэг мэдүүлэхдээ: "Би тэргүүн сонины газарт ерөнхий эрхлэгчээр ажилладаг. Отгонжаргал, Цэдэвсүрэн нарын энэ хэрэгт намайг яллагдагчаар татаж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаад гомдолтой байна. Отгонжаргал, Цэдэвсүрэн нар нь Монгол улсын Үндсэн хуульд заагдсан эрхийнхээ дагуу хэвлэн нийтэлж, мэдээгээ гаргасан. Хохирогч нартай

миний хувьд ямар нэгэн өс хонзон байхгүй. Редакторын хувьд сэтгүүлч нарын эрхэд халдаж, сэтгүүлч нарын бичсэн мэдээ, нийтлэлийг гаргахгүй гэх эрх байхгүй. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд зааснаар сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийхгүй байх талаар хуульчилж өгсөн байдаг. Миний хувьд Отгонжаргал, Цэдэвсүрэн нарын мэдээ, нийтлэлийг хэвлэн нийтлэхийг хориглох, хяналт тавих нь Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг зөрчсөн үйлдэл болж байгаа юм. Сэтгүүлч нар өөрийн хуулиар олгогдсон эрхээ эдэлж эдгээр мэдээллийг гаргасан. Мөн Зар суртчилгааны тухай хуульд ч гэсэн зааснаар надад сэтгүүлчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, нөлөөлөх эрх байхгүй. Хуулиараа хориглосон. Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зохиогчийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх хэсэгт бүтээлээ өөрийн болон зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтлэх, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх хэсэгт бүтээл болон түүний нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглоно гэсэн. Надад энэ сэтгүүлч нарын бичсэн нийтлэл, мэдээг засах, өөрчлөх эрх байхгүй. Сэтгүүлчийн эрхийг хамгаалж Хүний эрхийн түгээмэл тунхагийг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа Глоб интернэшнл ТББ-аас редакцийн хяналтыг урстгах талаар зөвлөмж гаргасан байдаг. Уг зөвлөмжид эрхлэгч, редактор нь сэтгүүлч нарын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох, хэвлэл мэдээллийн эрхлэгч, редактор нь сэтгүүлч нарынхаа бичсэн нийтлэлийн агууллагыг хянах, мөн нийтлэлийг нийтлүүлэхгүй байх, цалин хасах, загнах, нийтлэлээс нь хасахгүй гэсэн байдаг. Намайг Тэргүүн сонины эрхлэгч, үүсгэн байгуулагч гэсэн үүднээс яллагдагчаар татаж байгаад гомдолтой байна. Цэдэвсүрэнгийн бичсэн нийтлэлийг нийтлэхгүй гэж өөрт нь 4 удаа хэлсэн. Шүүгч, хуульч нартай холбоотой маргаантай асуудал учраас энэ нийтлэлээ дахин шалга гэж буцаасан. Цэдэвсүрэн хэлэхдээ явж шалгасан, мөн нотлох баримтууд надад хангалттай байгаа гэж хэлээд нийтэлсэн. Отгонжаргалын хувьд энэ үнэн бодит мэдээлэл юм. Даваа гэрчилнэ гэж хэлсэн. Тухайн үед түүний ах Даваа С1 телевизэд ажиллаж байсан, сэтгүүлч хүн байгаа юм. Энэ хүнээс байцаалт авч өгөөч гэж мөрдөн байцаагчид удаа дараа хүсэлт гаргасан ч хүсэлтийг маань шийдвэрлэж өгөөгүй. Хавтаст хэрэгт цугларсан баримтаас харахад нилээн хэдэн зөрүүтэй материал байдаг. Иргэний бүртгэлийн газраас лавлагаа авсан байдаг ба энэ лавлагаанд хохирогч Алтанхуягийг Ганчимэг гэдэг эхнэртэй, 3 хүүхэдтэй гэсэн байдаг. Гэтэл бусад нотлох баримтаар Сэлэнгэ гэдэг эхнэртэй гэсэн байдаг. Хавтаст хэргийг зөвхөн хохирогч талд ашигтай байдлаар л бүрдүүлж цуглуулсан бол шүүгдэгч миний ганц ч хүсэлтийг хангаагүй. Алтанхуяг гэдэг хүний охин Намуундарь гэсэн охины талаар гэнэтхэн гаргаж ирсэн. Сонины мэдээлэлд Намуундарь биш А.Намуунаа гэсэн л нэр байдаг юм. Гэрч Даваагийн мэдүүлгээр л намайг гэм буруутай гэж үзэж мөрдөн байцаагч сэжигтэнээр татсан явдалд гомдолтой байна. Даваа гэх хүн бол манай сонины ажилтан биш шүү дээ. Тэр хүн Тэргүүн сонин Алтанхуяг юм уу эсвэл Ардчилсан намын талаар ямар л муу мэдээлэл байна, аваад ир гэдэг гэсэн гэж мэдүүлсэн байдаг. Түүнээс нь болж намайг гэм буруутай гэж үзсэн. Зөвхөн сэтгүүлч нарыг буруутгаж, сонин хэвлэлийн ажилтан нарыг яллахад чиглэгдсэн мөрдөн байцаалтын ажиллагаа явагдсанд харамсаж байна” гэв.

Мөн шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд яллах болон өмгөөлөх талуудын саналаар дараахь нотлох баримтуудыг хэргийн материалаас шинжлэн судлав. Үүнд:

Хохирогч Н.Алтанхуягийн: "... Тэргүүн сонины 2012 оны 8 дугаар сар, №31 /360/ дугаарын 5 дугаар нүүрэнд "Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин" гэсэн нийтлэл гарсан байна. Надад Намуунаа гэдэг охин байдаггүй ийм учир уг асуудлыг шалгуулахаар хандсан. Надад покер тоглодог хүүхэд байдаггүй учир уг асуудлыг хуулийн дагуу шалгуулмаар байна" гэсэн мэдүүлэг /1 дүгээр хавтас 27-28 дугаар тал/;

Хохирогч П. Батсайханы: "Тэргүүн сонины 2012 оны 5 дугаар сар. №19 /348/ дугаарт мөн Үндэстэн сайтад "Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлзөж байна" гэсэн гарчигтай миний ажил албаны нэр төрд халдсан нийтлэл гарсан учраас Цагдаагийн байгууллагад хандах болсон юмаа. Уг нийтлэл нь дотроо 4 хэсэгт хуваагдсан байх бөгөөд аймгийн шүүхийн дарга уу, албад хамжлагатай нударган баян уу гэсэн хэсэг байх юмаа. Энэ хэсэг нь ор худал гүтгэлэг бөгөөд надад Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гурвын хооронд зөөлгөөд байдаг ачаа бараа гэхээр зүйл алга байна. Мөн ажил албаа хаяад хувийн ажлаа хөөцөлдөөд явдаг талаар бичсэн байна. Ерөнхий шүүгч хүн ажилдаа л байнга байна уу гэхээс биш гадуур явна гэж юу байхав дээ. Мөн эхнэр хүүхдээ албаны машинаар ажил, сургуульд нь хүргэж өгдөг талаар бичсэн байна. Сургуульд сурдаг хүүхэд надад байхгүй. Улаанбаатар хотод оюутан суралцаж байгаад төгсчихсэн байгаа. Манай эхнэр Гокод хуулийн зөвлөх хийдэг юм. Манай эхнэр өглөө 07 цаг 30 минутад нэгдсэн автобусаар яваад орой 18 цагийн үед ажлаасаа албаныхаа автобусаар гэрийнхээ гадаа буудаг. Ажлын машинаар эхнэр хүүхдээ зөөсөн асуудал байхгүй гэдгийг хэлмээр байна. Мөн шүүхийн хэдэн ажилчдыг өөрийн зарц барлаг шиг ашиглаж ногоогоо тариулж, ар гэрийнхээ нүүдэл суудлыг хийлгэдэг талаар бичсэн байна. Энэ ногоогоо суулгаж байгаа зурагт тамгын газрын дарга Ганчулуун бид хоёрын зураг байх юм ... Батсайхан албаны мөнгөөр зуслангийн байшин худалдаж аваад үүнийгээ өөртөө ашигласан талаар бичсэн байна. Энэ бол хамт олны хурал хийгээд шүүхийн ажилчдын дунд лагерт гардаг байшин байх хэрэгтэй гэж ярилцаад халамжийн мөнгө болох 1450000 төгрөгөөр 3 ширхэг байшин барих санаатай 48 ширхэг дүнз худалдаж аваад түүнийгээ Цагдаагийн байгууллагын зуслангийн хашаанд өрсөн бөгөөд одоог хүртэл уг дүнэнүүд байгаа" гэсэн мэдүүлэг /1 хавтас 32-33 дугаар тал/;

Гэрч Н.Намуундарийн: "...Би Н.Алтанхуяг сайдыг телевизээр харж байсан болохоос биш ямар нэгэн холбоо хамаарал байхгүй. Харин манай ахыг Дагвын Алтанхуяг гэдэг хүн байдаг бөгөөд ээжийн маань төрсөн ах, сая иргэдийн төлөөлөгчдийн хуралд Чингэлтэй дүүрэгт хүртэл нэр дэвшиж байсан юм. Нэг удаа манай ахын зураг нь сонин дээр гарчихсан байхаар нь найз нартайгаа сууж байхдаа энэ манай ээжийн ах байгаа юм, миний ааваас ялгаагүй хүн байгаа юмаа гэж хэлж байсан. Би покер тоглож байсан хүмүүсийг харж байсан, мэргэжлийн покерчин биш, тэгэж тоглож байгаа ч үгүй, асуудлыг маш дутуу шалгаж сонинд нийтэлсэн байна. Миний төрсөн эцэг бол Эрдэнэсүрэнгийн Төгс-Эрдэнэ гэдэг хүн байгаа. 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр нас барсан юм. Намайг хэн ингэж сэтгүүлчид хэлсэн болохыг би мэдэхгүй байна" гэсэн мэдүүлэг /1 хавтас 65-66 дугаар тал/;

Гэрч Д.Мөнхтуяагийн: "...Хохирогч хохирсоор байх уу хэсэгт бичигдсэн Мөнхтуяа гэдэг хүн бол би байна. Батсайхан шүүгч надтай уулзсан. Намайг уг нийтлэлийг бичсэн үү чи мэдэж байгаа юм гэж хэлсэн. Би уг нийтлэлийг бичүүлээгүй учраас мэдэхгүй гэдгээ хэлсэн" гэсэн мэдүүлэг /1 дүгээр хавтас 36-38 дугаар тал/;

Гэрч М.Ганчулууны: "...Манай шүүхийн ажилчдын хурлаар нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор зуслангийн байшинтай болох санал гаргаж ирээд эх үүсвэрийг ажилчдын нийгмийн асуудалд зарцуулахаар төсөвт суусан нэг удаагийн буцалтгүй тусламж зардал 1.450.000 төгрөг нийт алба хаагчдын нэр дээр гаргаад уг мөнгөөр 4 ширхэг торх худалдаж аваад цагдаагийн зуслан дээр 3 торхыг өрөөд 1 торхын өрөөгүй одоо хүртэл байж байгаа. Энэ мөнгийг зуслангийн байшинд зарцуулах шийдвэрийг манай ажилчдын хурлаас гарч бүгд дэмжсэн" гэсэн мэдүүлэг /1 дүгээр хавтас 40 дүгээр тал/;

Гэрч Б.Болорцэрэнгийн: "...Манай ерөнхий эрхлэгч Цоожчулуунцэцэг эгч маань мэдээ материалыг редакторлож мэдээллийг бичүүлдэг болсон" гэсэн мэдүүлэг /1 дүгээр хавтас 120 дугаар тал/;

Гэрч Д.Даваагийн: "...Сонины эрхлэгчдээ сонин болгоод хэлчихсэн чинь л нийтлэл болгоод бичээд аваад ир, мөн ардчилсан намын холбогдолтой мэдээлэл хэрэгтэй байна гэж хэлсэн гэж хүртэл хэлсэн юм. Уг мэдээллийг хүнээс сонсож байсан юм. Ямар хүнээс сонсож байснаа санахгүй байна. Алтанхуяг сайдын ерөнхий сайдад нэр дэвшиж байх үед хүмүүс нууц хүүхэдтэй гээд л яриад байсан юм. Хаана хэзээ ярьж байсныг нь мартчихсан байна" гэсэн мэдүүлэг /1 дүгээр хавтас 134 дүгээр тал/;

Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлалын яамны харъяа Төрийн хэлний зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 2/44 дүгээр шинжээчийн дүгнэлтэнд:

"1. "Покерчин" гэдэг үгийн тухайд Энэ үг покер+ чин гэсэн бүтэцтэй. Покер гэдэг нь англи хэлний "poker" гэсэн үг бөгөөд үндсэн утгаараа хөзрийн тоглоомын нэг хувилбарын нэр юм байна. Мөнгө тавьж хожих, хожигдож нааддаг тул мөрийтэй тоглоомын нэгд тооцогддог. Казинод тоглодог байна. Покер гэдэг нэр үндсэн дээр монгол хэлний -чин гэсэн бүтээврийг залгаж покер тоглодог хүмүүнийг нэрлэх үгийг бүтээжээ. Покерчин гэдэг мэргэжил байдаг эсэх нь бидэнд тодорхойгүй. Тиймээс нэр бүхий хүнийг "мэргэжлийн покерчин" хэмээсэн нь үнэн эсэхийг шалган тогтоох шаардлагатай. Батлагдахгүй аваас гүтгэн доромжилсон хэрэг болно. Покерийн өөр нэг төрөл нь талс бүртээ 1-ээс 6 хүртэлх тоо бүхий зургаан талт 5 ширхэг ясан шоог хаяж 2-оос 4 хүн мөнгө тавьж, хожиж хожигдож нааддаг мөрийтэй тоглоом юм байна.

2. "Улаан покерчин, бүр багагүй донтчихсон" гэсэн хэллэгийн тухайд Улаан гэдэг үгийн олон утга дотроос энд "хэтэрхий" гэсэн утгийг илэрхийлэх хэллэгт ордог шинжийг сонгон авч "дандаа мөрийтэй покер тоглодог" гэсэн утгийг илэрхийлжээ. "донтчихсон" гэдэг нь покер тоглоход хэт шунан тачааддаг" гэсэн утгатай тул "бүр багагүй донтчихсон" гэдэг нь "покер тоглох хэт их шунал тачаалтай" гэсэн утгийг илэрхийлсэн байна. Нэр бүхий хүмүүнийг доромжилж нэр төр, алдар хүндийг зориуд санаатайгаар гутаан доромжилсон эсэхийг холбогдох хүний үйлдлийг шалган дүгнэснээр тогтоох боломжтой.

3. "Шар сэмжилсэн, сэмжлээгүй" гэсэн хэллэгийн тухайд Монгол хэлний "шар сэмжлэх" гэсэн хэллэг нь "хөгширч нас ахиснаа үл тоон, шалиг зан гаргах" гэсэн утгийг илэрхийлдэг. Хүмүүнийг муу хэлэх, доромжлох зорилгоор хэрэглэдэг болно" гэсэн дүгнэлт /1 дүгээр хавтас 171 дүгээр тал/;

Шүүгдэгчдийн хувийн байдлыг тодорхойлсон баримтууд болох иргэний үнэмлэхийн лавлагаа /1 дүгээр хавтас 70, 188, 236 дугаар тал/, оршин суух газрын тодорхойлолт /1 дүгээр хавтас хэргийн 68, 186, 234 дүгээр тал/, ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /1 дүгээр хавтас 71, 189, 237 дугаар тал/, дипломын хуулбар /1 дүгээр хавтас 190-191 дүгээр тал/ зэргийг уншиж сонсгох замаар шинжлэн судаллаа.

Шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн эдгээр баримтуудыг мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлсэн байх тул энэ хэргийг шийдвэрлэх боломжтой хэргийн бүрдэл хангагдсан байна гэж шүүх дүгнэлээ.

НЭГ:

Шүүгдэгч Б.Отгонжаргал нь Тэргүүн сонины газар дадлагажигч сэтгүүлчээр ажиллаж байхдаа 2012 оны 8 дугаар сарын 31 /360/ дугаарт "Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин" гэсэн нийтлэл бичиж хэвлүүлсэн байх ба уг нийтлэл нь

хохирогч Н.Алтанхуягийн нэр төр, алдар хүндийг гутаасан шинжтэй, илт худал гүжирдлэг болох нь Эд мөрийн баримтаар хураан авч хэрэгт хавсаргах тухай мөрдөн байцаагчийн 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн тогтоол /1 дүгээр хавтас 159 дүгээр тал/, Тэргүүн сонины 2012 он. 8 дугаар сар. №31 (360) эх хувь, хохирогч Н.Алтанхуягийн мэдүүлэг /1 дүгээр хавтас 161 дүгээр тал/, "улаан покерчин, бүр багагүй донтчихсон, шар сэмжилсэн, сэмжлээгүй" гэсэн үгийн утгыг тайлбарласан Төрийн хэлний зөвлөлийн шинжээчийн 2012 оны 2/44 дүгээр дүгнэлт /1 дүгээр хавтас 171 дүгээр тал/, шүүгдэгч Б.Отгонжаргалын мөрдөн байцаалтын үед сэжигтнээр мэдүүлсэн "Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин гэсэн нийтлэлийг би бичсэн. Сонинд ямарваа нэг нийтлэл бичих гэж байгаа тохиолдолд редактор эхэлж хянана, дараа нь хариуцлагатай нарийн бичгийн дарга зэрэг албан тушаалтай хүмүүс хянаж байж нийтлэлийг гаргадаг юм" /1 дүгээр хавтас 178 дугаар тал/, яллагдагчаар "уг мэдээллийг хүнээс сонссон мэдээ байсан бөгөөд бодитой эсэхийг еерийнхөө хэмжээнд шалгахад тогтоогдож байсан учраас энэ гарчигтэй мэдээллийг биччихсэн юм. Интернэтэд ерөнхий сайдын талаар байдаггүй учраас чадах чинээгээрээ л шалгаж тогтоогоод уг мэдээг бичсэн юм. Би мэдээ бичих шаардлагатай болчихоод л бичих болсон юм. Ямар нэгэн улс төрийн хувийн санаа зорилго байхгүй" /1 дүгээр хавтас 182 дугаар тал/, "Ерөнхийдөө Тэргүүн сонины редакцийн бодлого нь Ерөнхий сайд Алтанхуягийн эсрэг намын сонин байгаа юмаа. Тийм учраас байнга сөрөг мэдээллийг Алтанхуягийн эсрэг нийтэлдэг юм. Энэ ч утгаараа би Цоожчулуунцэцэг эгчид ийм нэг мэдээ материал байна гэж хэлсэн чинь өө за гээд л уухайн тас мэдээллийг авч нийтэлсэн. Надаас бол чи үүнийгээ баталсан юм уу нотолсон юм уу гэж огт асууж тодруулж байгаагүй. Би уг материалыг ах Б.Даваагаас сонсож байсан юм" /2 дугаар хавтас 5 дугаар тал/, шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгчээр "би гурван мэдээ бичсэнээс нэг мэдээг нь тавьсан байсан, сонины эрхлэгч Цоожчулуунцэцэг эгч гарчигийг нь тавьсан. Би энэ мэдээг сайн шалгалгүй сонинд нийтэлсэн буруугаа хүлээж байна. Харин хувийн болон улс төрийн аливаа сонирхол байхгүй" гэсэн мэдүүлгүүд, гэрч Б.Даваагийн "Би өөрийн төрсөн дүү Отгонжаргалд уг мэдээллийг өгсөн нь үнээн. Би өөрийн дүүдээ сонин болгож энэ мэдээллийг ярьсан. Уг мэдээллийг сонин болгож л ярьсан болохоос биш хүний нэр төр алдар хүндэд халдах санаа зорилгыг агуулан уг нийтлэлийг захиалгаар дүүдээ өгсөн асуудал огт байхгүй. Ингээд сонинд нийтлэл болгоод биччихнэ ч гэж бодоогүй. Тухайн үед надад хэлэхдээ сонины газарт дадлага хийж байгаа гэж хэлж байсан. Нийтлэл тавих хэмжээний дадлага хийж байгаа гэдгийг нь би мэдээгүй. Бичсэн болохыг нь ч гэсэн мэдээгүй. Нэг өдөр л над руу утсаар яриад та тэр мэдээллээ хаанаас хэнээс авсан юм бэ би сонинд биччихсэн чинь буруудчихлаа гээд байсан юм. Тэгэхээр нь би утсаар загнаж баттай эх сурвалж байхгүй зүйлийг яах гэж бичдэг юм бэ гэхэд сонины эрхлэгчдээ сонин болгоод хэлчихсэн чинь л нийтлэл болгоод бичээд аваад ир, ... гэж хүртэл хэлсэн юм. Уг мэдээллийг би хүнээс сонсож байсан юм. Ямар хүнээс сонсож байснаа санахгүй байна" /2 дугаар хавтас 19 дүгээр тал/ гэсэн мэдүүлгүүд зэрэг нотлох баримтуудаар тогтоогдож байна.

ХОЁР:

Шүүгдэгч Л.Цэдэвсүрэн нь Тэргүүн сонины газарт орлогч эрхлэгчээр ажиллаж байхдаа 2012 оны 5 дугаар сарын №19 /348/ дугаарт "Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлзөж байна" гэсэн нийтлэл гарган хэвлүүлж, Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч П.Батсайханы нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэгийг олон нийтэд тараасан болох нь эргийн 17, 131 дүгээр талд авагдсан Тэргүүн сонины 2012 оны 5 дугаар сарын 19 дэх дугаарын хуулбар, эд мөрийн баримтаар тооцож, хэрэгт хавсаргах тухай мөрдөн байцаагчийн тогтоол /1 дүгээр хавтас 125 дугаар тал/, хохирогч П.Батсайханы мэдүүлэг /1 дүгээр хавтас 32-33 дугаар тал/, "тус шүүхийн Тамгын газрын даргын 2010 оны 17 дугаар тушаалаар 1.450.000 төгрөгийг шүүхийн ажилчдын нийгмийн

асуудлыг шийдэх зорилгоор зуслангийн байшинтай болох зэрэг ажилчдын хурлаас гарсан саналаар үндэслэн гаргаж, гурван торх /дүнзэн байшингийн мод/ худалдан авсан, ажилчид өөрсдөө мөнгө гаргаад Хоргын тогоо, Тэрхийн цагаан нуур руу аялсан, шүүхийн автомашинд сард 150.000 төгрөгийн шатахууны хэмжээтэй" болохыг тус тус гэрчилсэн тус шүүхийн Тамгын газрын дарга М.Ганчулуун, жолооч Ж.Батгэрэл, нягтлан бодогч Л.Алтансүх, нягтлан Д.Сувдаа нарын гэрчийн мэдүүлгүүд /1 дүгээр хавтас 40-43 дугаар тал/, Орхон аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн даргын 2012 оны "Буцалтгүй тусламж олгох тухай" 17 дугаар тушаал хавсралт, шүүхийн үндсэн хөрөнгийн жагсаалт, шатахууны зарцуулалт зэргийн хуулбар /1 дүгээр хавтас 45-52 дугаар тал/, шүүгдэгч Л.Цэдэвсүрэнгийн мөрдөн байцаалтын үед сэжигтнээр мэдүүлсэн "Би Тэргүүн сонины 348 дугаарт Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлзөж байна гэсэн нийтлэлийг бичсэн. Надад энэ нийтлэлийг бичихэд хэн нэгэн гаднаас нөлөөлсөн асуудал бол байхгүй. Би хэнийг ч хэлмэгдүүлээгүй, хэнийг ч гүтгээгүй. Харин шүүгч Батсайханы талаар бичсэн асуудлыг маань шалгалгүй намайг шалгаад байгаад нь би гайхаж байна" /1 дүгээр хавтас 64 дүгээр тал/, яллагдагчаар мэдүүлсэн "Надад уг нийтлэлийг бичих болсон ямар нэгэн ашиг сонирхол, хувийн өш хонзон санасан зүйл байхгүй. Сэтгүүлч хүн олсон эх материалаа шалгаад түүнийгээ хэвлэн нийтлэх эрхтэй" /1 дүгээр хавтас 66 дугаар тал/, нийтлэлийн дагуу Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны шалгалтын материалуудын хуулбар /1 дүгээр хавтас 88-120 дугаар тал/, "Ерөнхий шүүгч П.Батсайханы талаар бичсэн мэдээлэлд Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай" Нийслэлийн прокурорын газрын 2012 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 502 дугаар тогтоол /1 дүгээр хавтас 121 дүгээр тал/ зэрэг нотлох баримтуудаар тогтоогдож байна.

Шүүгдэгч Б.Отгонжаргал, Л.Цэдэвсүрэн нар нь дээрх нийтлэлийг бичиж Тэргүүн сонинд хэвлүүлэхдээ уг мэдээллийн үнэн худал эсэхийг нягталж шалгаагүй, хохирогч нарын нийгэмд үнэлэгдэх зүй ёсны үнэлгээг доройтуулж гажуудуулсан байдалаар бичиж, улмаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тараасан байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бүрэн хангасан байна гэж шүүх дүгнэв.

Шүүгдэгч Л.Цэдэвсүрэн нь мэдээллийн эх сурвалжаа бүгдийг нь шалгаж нийтлэлийг бичсэн гэж мэдүүлж байгаа боловч хохирогчийг илт гүжирдсэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар няцаагдаж байна.

ГУРАВ:

Шүүгдэгч Б.Цоожчулуунцэцэг нь Тэргүүн сонины Ерөнхий эрхлэгчээр ажиллаж байхдаа дээрх хоёр нийтлэлийн бодит үнэнийг шалгаж тодруулах талаар арга хэмжээ авахгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслд нийтэлж, олон нийтэд тараах боломж олгож хамжигчаар хамтран оролцсон болох нь тогтоогдож байна.

Тэрээр мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэгт "Уг мэдээллийг бичсэн сэтгүүлч нар нь байгаа тул тэд өөрсдөө хариуцлагаа хүлээх ёстой, алдаа гаргасны төлөө эсвэл энэ хүмүүсийн өмнөөс би хариуцлага хүлээх ёсгүй, Монголын сэтгүүл зүйн түүхэнд сэтгүүлчийн өмнөөс сонин хэвлэлийн удирдлагыг яллагдагчаар татаж байсныг нь би лав мэдэхгүй байна. Хоёр хүний өмнөөс намайг буруутан болгож байгааг хүлээн зөвшөөрөхгүй" гэж өөрийн гэм буруугийн талаар маргаж байгаа боловч, хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан "хэвлэл мэдээллийн хэрэгсл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэсэн заалт болон Тэргүүн сонины Ерөнхий эрхлэгчийн үүрэгт ажлын хувьд дээрх хоёр нийтлэлийг сониндоо хэвлэх зөвшөөрөл олгосон, сэтгүүлч нарт тодорхой хэмжээний

сэдийн чиглэл өгөх зэргээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт оролцсон байна.

Иймд шүүгдэгч Б.Отгонжаргал, Л.Цэдэвсүрэн, Б.Цоожчулуунцэцэг нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй бөгөөд шүүгдэгч нарын үйлдэл оролцоог харгалзан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн зохих хэсгийг тус тус журамлан ял шийтгэх нь зүйтэй гэж шүүх үзлээ.

Дурьдаж байгаа хоёр нийтлэлийг илт худал гүтгэлэг байна гэж шүүх дүгнэсэн учраас хохирогч нарын нэхэмжлэлийн шаардлагыг үндэслэн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсэгт заасны дагуу нийтлэлүүдэд тус тус няцаалт хийх үүргийг Тэргүүн сонины газарт даалгах нь зүйтэй.

Хохирогч Н.Алтанхуяг нь нэхэмжлэлийн өөр шаардлага гаргаагүй байна.

Харин хохирогч П.Батсайханы өмгөөлөгч Т.Мөнхтуяа шүүхийн хэлэлцүүлэгт "Тэргүүн сонины 2012 оны 5 дугаар сарын 19 дугаарыг нийт 600 хувь хэвлэсэн тоог тухайн сонины нэг бүрийн үнэ болох 300 төгрөгөөр тооцож, 1.800.000 төгрөгийг гэм хорын хохирол"-д тооцон Тэргүүн сонины газраас нэхэмжилж байгааг шүүх шийдвэрлэх боломжгүй байна. Учир нь, хохирогч П.Батсайхан нь мөрдөн байцаалтын шатанд болон шүүхэд бичгээр тийм нэхэмжлэлийн шаардлага гаргаагүй бөгөөд өмгөөлөгч Т.Мөнхтуяад "нэхэмжлэл гаргах" тухай итгэмжлэл олгоогүй байна.

Гэвч, хохирогч П.Батсайхан нь өөрөө болон бусдад итгэмжлэл олгох замаар дээрхтэй адил ямарваа нэхэмжлэлийн шаардлагыг жич гаргаж, түүнийгээ нотолсон баримт бүрдүүлж, иргэний журмаар шийдвэрлүүлэх эсэх эрхийг нээлттэй үлдээх нь зүйтэй гэж үзэв.

Шүүх шүүгдэгч нарт ял шийтгэхдээ тэднийг анх удаагаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, тэдгээрийг нийгмээс тусгаарлахгүйгээр хуульд заасан торгуулийн ял шийтгэлийг оногдуулж шийдвэрлэв.

Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг буюу 140.400 төгрөгийг 51-ээс 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тогтоосон болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 290, 294, 298 дугаар зүйлүүдэд тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Прокуророос шүүгдэгч Б.Отгонжаргал, Л.Цэдэвсүрэн нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэнийг мөн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, шүүгдэгч Б.Цоожчулуунцэцэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэнийг мөн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар тус тус зүйлчилсүгэй.

2. Шүүгдэгч Барга овогт Болдын Отгонжаргал, Шаавай овогт Лхамжавын Цэдэвсүрэн нарыг тусдаа үйлдлээр хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэгийг олон нийтэд тараасан, шүүгдэгч Мэргэд овогт Баянмөнхийн Цоожчулуунцэцэгийг хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал

гүжирдлэгийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон гэмт хэрэг тус тус үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Отгонжаргалыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 7.160.400 төгрөгөөр, шүүгдэгч Л.Цэдэвсүрэнг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 55 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 7.722.000 төгрөгөөр торгох, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Цоожчулуунцэцэгт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 14.040.000 төгрөгөөр торгох ял тус тус шийтгэсүгэй.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Б.Отгонжаргалын 2013 оны 9 дүгээр сарын 02-ны өдрөөс 03-ны өдрийг хүртэл цагдан хоригдсон 1 хоногийг тухайн үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлэн 192.000 төгрөгийг хасч, бүгд биечлэн эдлэх ялыг 6.965.400 төгрөгийн торгох ялаар тогтоосугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч нар нь торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл торгох ялын хэмжээнээс хамааруулан 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болохыг дурьдсугай.

6. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7 дахь хэсэгт зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн Тэргүүн сонины 2012 оны 8 дугаар сарын №31 (360) дугаарыг эх хувиар нь хэргийг хадгалах хүртэл хугацаагаар хэрэгт хавсаргасугай.

7. Хохирогч П.Батсайхан нь өөрт учирсан гэм хорын хохирлоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар жич нэхэмжлэх эрхтэй болохыг дурьдсугай.

8. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсэгт заасныг баримтлан хохирогч П.Батсайхан, Н.Алтанхуяг нарын талаар бичсэн нийтлэлдээ няцаалт хийж, тус сониндоо залруулга гаргахыг Тэргүүн сонины газарт даалгасугай.

9. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч, хохирогч, өмгөөлөгч нар эс зөвшөөрвөл тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор Нийслэлийн шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор мөн хугацаанд эсэргүүцэл бичих эрхтэйг тайлбарласугай.

10. Хэрэв давж заалдах гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болтол шүүгдэгч нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

ШҮҮГЧИД

Б.ЗОРИГ

Г.БУЯННЭМЭХ

Г.ЕСӨН-ЭРДЭНЭ

**ЕРӨНХИЙ САЙДАА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭЗЭН
БАЙНА ГЭДЭГ ГЭМТ ХЭРЭГ ЮМ УУ**

/Ил захидал/

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг танд энэ өдрийн мэнд хүргэе.

Ардчилал ялж, Ардчилсан нам Шинэчлэлийн Засгийн газар байгуулж, тус намын дарга Засгийн газрыг толгойлж байгаа энэ үед ардчиллын гол билэг тэмдэг болсон чөлөөт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл чөдөрлөгдөж, сэтгүүлчдийн эрх ашиг боомилогдож, шүүх цагдаагийн хаалга татах болсоор удаж байна. Тэр ч бүү хэл хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэн байх нь гэмт хэрэг болон хувирч байгаа учраас Танд энэхүү ил захидлыг илгээж байгаа юм.

Шинэчлэлийн Засгийн газрын Тэргүүн Н.Алтанхуяг таны гаргасан нэхэмжлэлээр өнөөдөр гурван сэтгүүлч “Эрүүгийн хууль”-ийн 111-ийн 2-т заасны дагуу Чингэлтэй дүүргийн шүүхээс ял сонсож, ял сонсохоор Чингэлтэй дүүргийн прокурорын газраас Яллах дүгнэлт гардаж аваад байгааг Танд дуулгах нь илүүц байхаа гэж бодож байна. Учир нь Монгол Улсын Ерөнхий сайд Та өөрийн биеэр Чингэлтэй дүүргийн мөрдөн байцаагчид мэдүүлэг өгч, хавтаст хэрэгтэй танилцаж, өөрийнхөө гараар “Энэ хэргийг шүүхээр шийдүүлэх хүсэлтэй байна” гэж бичиж өгсөн учраас энэ асуудлыг маш сайн мэдэж байгаа нь дамжиггүй.

Энэ хэргийг шалгаж буй мөрдөн байцаагч намайг дуудаж мэдүүлэг авахдаа “Та нарын буянаар Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягаас мэдүүлэг авч үзлээ” хэмээн баясаж байгааг хараад инээд хүрч, бас айж болгоомжлох сэтгэл төрж байсныг нуугаад яахав. Миний энэ болгоомжлол талаар болсонгүй. Учир нь мөрдөн байцаагч “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн 21.2-р зүйл ангийг эрс зөрчиж, нэхэмжлэгч, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг Танд л ашигтайгаар хавтаст хэргийг бүрдүүлсэн байна. Таны гаргасан хүсэлтийн дагуу гурван сэтгүүлч нэг өдөр ял сонсох гэж байгаа бөгөөд энэ гурван сэтгүүлчийн хоёр нь нялх хүүхэдтэй. Мөрдөн шалгах явц бүхэл бүтэн жил гаруй хугацаанд үргэлжилж, хуулийн байгууллагыг хүндэтгэн, дуудсан цагт нь очдог сэтгүүлч нарыг залхаан цээрлүүлэх маягаар асуудалд хандаж, төрөх гээд өвдөж байгаа бүсгүйг гараад ир “Хавтаст хэрэгтэйгээ танилц” хэмээн тохуурхаж, төрөөд дөнгөж хэдхэн хонож байгаа хүнд хавтаст хэрэг аваачиж өгөн орцонд гарын үсэг зуруулж, бүтэн жил тун сайн ажиллаа. Гэхдээ мөрдөн байцаагч мэдээллийн эх сурвалж, гэрчүүдийг дутуу байцаасан, мэдээлэл өгсөн хүнийг энэ хэрэгт ямар ч холбогдолгүйгээр орхисон байгаа гэдгийг Танд уламжилъя.

Тэр ч бүү хэл мөрдөн байцаагч Улсын бүртгэлийн Ерөнхий газраас лавлагаа авсан бөгөөд энэ лавлагаагаар Норовын Алтанхуяг нь эхнэр Ганчимэгтэй амьдардаг гэсэн байх юм. Н.Алтанхуяг таныг Х.Сэлэнгээ гэдэг эхнэртэй гэдгийг ард түмэн бид мэдэх билээ. Гэтэл мөрдөн байцаагч Ганчимэг гэдэг эхнэртэй гэсэн тодорхойлолтоо сэтгүүлчдийг буруутгах гол нотлох баримтаа болгож байна. Үүнээс үүдэн Эрүүгийн хуулийн 253.2.-т зааснаар Нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлж, сэтгүүлч нарт ял шийтгэл оноох гэж байна гэж үзэж байна.

Эсвэл Ерөнхий сайд Н.Алтанхуяг та Ганчимэг, Х.Сэлэнгээ гэдэг хоёр эхнэртэй болж таарч байгаа юм. Уг нь сэтгүүлч мэдээллийн эх сурвалжаа нууцлах бүрэн эрхтэй. Гэвч хууль хяналтынхан “Ерөнхий сайд Н.Алтанхуягийн охин мэргэжлийн покерчин” гэсэн гарчигтай мэдээг бичсэн залуу сэтгүүлчийг жил гаруй шалгаж байцаахдаа мэдээллийн эх сурвалжийг нь хэлүүлж, бас өөрийгөө таны охин гэж ярьдаг Намуундарь охиноос мэдүүлэг авчээ. Өөрийгөө таны охин гэж ярьдаг энэ бүсгүй “Надад Алтанхуяг нэртэй ах байгаа. АН-д байдаг” хэмээн мэдүүлэг өгсөн нь эргэлзээ төрүүлсээр байна. Тиймээс Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг таныг Нармандахын Намуундарь

гэдэг охинтой ямар нэг холбоогүй гэж үзэх боломжгүй бөгөөд уг хэрэгт буруутан болоод байгаа сэтгүүлч таныг генийн шинжилгээ өгөхийг ч хүсэх нь хууль ёсны хэрэг болох биз.

Б.Цоожчулуунцэцэг миний бие хэвлэл мэдээллийн салбарт хорь шахам жил ажиллаж байгаа жирийн нэгэн сэтгүүлч. Би 2011 онд долоо хоног тутмын “Тэргүүн” сониныг нэгэн хэвлэлийн компаниас худалдан авсан бөгөөд өдгөө тус сониныг эрхлэн гаргаж байгаа болно. Миний хувьд таны гомдол гаргаад байгаа энэ мэдээллийг бичээгүй, сэтгүүлчдэд үүрэг өгч бичүүлээгүй. Зөвхөн “Тэргүүн” сонины эрхлэгч учраас гэмт хэрэгтэн гэж мөрдөн байцаагч үзэж, прокурор яллах дүгнэлт бичиж, шүүгч ял сонсгохоор зэхэж байгаад харамсаж байна.

“Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн 196.1.-д “Тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь хангалттай нотлох баримтаар нотлогдож байвал уг этгээдийг яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэнэ” гэж заасан байдаг. Гэтэл намайг зөвхөн “Тэргүүн” сонины эрхлэгч учраас гэм буруутай гэж үзэн Б.Отгонжаргал, Л.Цэдэвсүрэн нарын хамт “Эрүүгийн хууль”-ийн 111-р зүйлийн 2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татав. Монголын сэтгүүл зүйн түүхэнд сэтгүүлчдийн бичсэн мэдээ мэдээллээс болж, сонин хэвлэлийн эзнийг яллаж байгаа анхны тохиолдол энэ болж байгаа юм. Шинэчлэлийн Засгийн газрын Тэргүүн та хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөг хааж боогдуулах шинэ аргыг сэдэж байгаад ч мөн харамсаж байна. Таны энэ үйлдэл өнөөдөр Монголд үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллага, сонин хэвлэлийн эрхлэгч нар, телевизүүдийн захирал, мэдээллийн веб сайтуудын эздийн анхаарлыг татаж, тэд таныг ажиглаж байгаа гэдгийг та сайн мэдэж байгаа.

Ард түмнийхээ төлөө чөлөө завгүй ажиллаж, амарч чадахгүй зүтгэж байгаа хэмээн ярилцлага өгч, сэтгүүлч нараар өөрөө, өөрийгөө сурталчлуулах ажлыг тун гарамгай зохион байгуулдаг Монгол Улсын Ерөнхий сайд маань өрөөндөө сэтгүүлчдийн эсрэг нэхэмжлэл бичиж, мөрдөн байцаагч нарыг дуудан мэдүүлэг өгөөд сууж байгаад харамсаж байна.

Та хувь хүн боловч нийгэмд үлгэр дуурайлал үзүүлэх учиртай, хариуцлага хүлээсэн төрийн өндөр дээд албан тушаалтан учраас Таны гэр бүл, бизнес, хүргэн бэрүүдийн тухай асуудлыг сонин хэвлэлүүд зүй ёсоор хөндөж тавьдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх байх аа.

Та Япон улсын Ерөнхий сайдтай уулзахдаа, мөн Монгол төрийн албан ёсны бүхий л арга хэмжээнд Х.Сэлэнгээ гэдэг эмэгтэйд өөрийн гэргий хэмээн дагуулж хамт оролцдог ч Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Ганчимэг гэдэг эмэгтэйтэй гэрлэлтээ батлуулсан албан ёсны эхнэр нөхөр мөн гэсэн тодорхойлолт гарч ирж, энэ нь сэтгүүлчдийн эсрэг нотлох баримт болж хувираад байгаад гайхаж байна.

Хувь хүний хувийн амьдрал, хэн хэдэн эхнэртэй байх нь хэнд ч хамаагүй гэж Та үзэж байж болох юм. Гэвч Монгол Улсын “Гэр бүлийн тухай хууль”-ийн 6-р зүйлийн 2-т “Эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна” гэж заасан байдгийг Ерөнхий сайд Таныг мэдэж байгаа байхаа гэж найдаж байна.

Одоогоос хэдэн жилийн өмнө Н.Алтанхуяг чацарганы бизнес эрхлэдэг гэсэн утга агуулга бүхий мэдээ бичсэн сэтгүүлч шүүхээр орж, буруутай гэдэг дүгнэлт гарч байсныг санаж байна. Харин өнөөдөр Монгол хүн бүр таныг хувьдаа “Хаан жимс” нэртэй чацарганы тариалан эрхэлдэг томоохон компанитай гэдгийг тань мэднэ. Хэд хэдэн газар салбартай таны чацарганы тариалан өргөжин тэлж байгаа. Тэр ч бүү хэл эх орноо манах үүрэг хүлээсэн цэрэг эрс таны чацарганыг манахаар зуу, зуугаараа Сэлэнгэ аймагт ажиллах гэж байгаа тухай нутгийн иргэд ярьж байна билээ. Таны чацарганы тариаланг явдлын далимд үзэж сонирхсон. Сайхан ургаж байна лээ, ургац арвин байг ээ. Харин ард иргэдийн амьдрал таны хувийн компанийн ургац шиг арвин, өргөн дэлгэр байж чадахгүй байгаа гэдгийг Танд сануулъя. Ялангуяа ардчиллын билэг тэмдэг болсон хэвлэлийн эрх чөлөө аль хэдийнээ хатаж гандаж, одоо хагдарч унахад бэлэн болоод байгааг дуулгахад харамсалтай байна.

Таны нэхэмжлэлээр эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа сэтгүүлчдэд Чингэлтэй дүүргийн прокурорын газраас яллах дүгнэлт бичээд байгаа юм. Энэхүү 184 тоот яллах дүгнэлтэнд Чингэлтэй дүүргийн прокурор, Хууль цаазын зөвлөх А.Дэлгэрмөнх “Шүүх хуралд нэхэмжлэгч Н.Алтанхуягийг оролцуулах хүсэлтэй байна” гэдэг саналаа Чингэлтэй дүүргийн шүүхэд гаргаад байгаа. Тиймээс эрхэм Ерөнхий сайд Норовын Алтанхуяг таныг Төрийн өмнөөс яллах дүгнэлт бичиж байгаа прокурорын хууль ёсны хүсэлтийг хүлээн авна, шүүх хуралд өөрийн биеэр ирнэ, бид тантай шүүх хурал дээр нүүр тулан уулзана гэдэгтээ итгэлтэй байна. МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хууль дуудсан бол тэр хүн зангиагаа засаад гутлаа өмсөөд очих ёстой” гэж хэлснийг танд сануулах нь илүүц бизээ.

Мөн сонин хэвлэлд мэдээлэл бичсэн сэтгүүлчид, сонин хэвлэл эрхлэн гаргаж байгаагийнхаа төлөө эрүүгийн гэмт хэрэгтэн болж хувираад байгаа миний бие Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл, Монголын Сонины холбоо, “Глоб интернейшнль” ТББ, Монголын сайтын холбоо зэрэг байгууллагад хандаж, үйл явдлын талаар хэвлэлийн бага хурал хийж, Олон улсын хүний эрхийн байгууллагад гомдол хүсэлт гаргаж, хэвлэн нийтлэх, сонин хэвлэл эрхлэн гаргах хуулиар олгогдсон эрхээ хамгаалахын төлөө тэмцэх болно.

Сэтгүүлч хүний хувьд улс орны амьдрал, нийгэм эдийн засгийн байдал хүндхэн байгааг бид сайн мэдэрч байгаа. Гэвч ийм цаг үед эрхэм Ерөнхий сайд тантай энэ тухай асуудлаар бус харин таны адармаатай, ээдрээтэй гэр бүлийн асуудлаар маргалдаж, мэтгэлцэх болсондоо харамсаж байна.

**“Тэргүүн” сонины ерөнхий эрхлэгч Б.Цоожчулуунцэцэг
Сэтгүүлч Болдын Отгонжаргал
Сэтгүүлч Лхамсүрэнгийн Цэдэвсүрэн**

Хавсралт 5.

Глоб интернешнл ТББ-д

Миний нэр МҮОНТ-ийн Монголын мэдээ агентлагийн редактор М.Бямбасүрэн 2013 оны 4 сард Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрөөр “цагаан будаанаас хар тугалга илэрлээ” сурвалжлагыг явуулсан.

Тухайн үед худалдаанд зарагдаж байсан цагаан будааны төрөл бүрээс 1 кг ийг өөрийн мөнгөөр худалдан авч МУИС-ийн Хими судлалын тэнхимийн явуулын лабораторид шинжлүүлэхэд Тэсо ХХК-ийн цагаан будаанаас хүнд металл буюу хар тугалганы хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их илэрсэн. Гэхдээ тухайн лаборатори нь итгэмжлэгдээгүй тул энэ талаар мэдээний ярилцлаган дээрээ дурьдаж, тексэн дээрээ энэ талаар холбогдох албаныханыг анхаарч судлахыг сануулсан. Мөн хар тугалга нь хүний биед хэрхэн нөлөөлдөг талаар мэдээлсэн.

Мөн тухайн шуурхай шинжилгээний хариуг авсаны дараа Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын эрх бүхий ажилтануудаас хил дээр орж байгаа цагаан будаанаас ямар шинжилгээ авдаг талаар болон хүнд металлын шинжилгээ хийдэг эсэхийг лавласан. Тухайн үед МХЕГ ярилцага өгөх хүн олдохгүй нэлээд удаан хүлээлгэж хөөцөлдүүлсэний эцэст хүнд метал болон шаардлагатай шинжилгээг хийдэг гэсэн хариу өгсөн. Харин би Замын-Үүдийн хил боомт дээр ажилладаг лаборторийн эрхлэгчээс таньдаг хүнээсээ лавлуухад тийм шинжилгээ хийдэггүй гэсэн хариу өгсөн. Үүнийг би текстэн дээрээ дурьдаж өгсөн.

Цагаан будаанаас хар тугалганаас илэрсэн мэдээг би тухайн үед мэдээллийн ВВС агентлагийн сайтаас харж энэ талаар судлаж мэдээлэл бэлтгэх санаа төрсөн. Учир нь тухайн сайтан дээр БНХАУ-аас АНУ-д экспортлож байгаа цагаан будаанаас хар тугалга зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгааг мэдээлж үүний шалтгааныг тус улсын цагаан будааны талбайг хүнд үйлдвэрийн цэвэршүүлээгүй усаар услаж байгаатай холбон тайлбарласан байсан. Манай улс ч цагаан будааны 80 гаруй хувийг БНХАУ-аас цагаан будуу экспортлог тул шалгаж үзэх хэрэгтэй гэж бодсон.

Манай агентлагийн хувьд камер хүрэлцээ муутайгаас сурвалжлагч нар тэр бүр эрэн сурвалжлах мэдээ хийх боломжгүй. Учир нь сурвалжлагч бүр амралтын өдрөөс бусад өдөр өглөө бүр зурганд явдаг төдийгүй, тухайн өдрийн мэдээгээ өдөрт нь багтааж өгөх шаардлагатай байдаг. Энэ нь өдөр олон цагаар камер авч яваад мэдээгээ нийлүүлэхгүй гэвэл Цагийн хүрдийн мэдээ дутах аюултай байдаг тул ахлах редакторууд тухайн өдрөө сурвалжлагчийн мэдээг заавал оруулна гэсэн шаардлагыг ихэнхдээ тавьдаг. Энэ шалтгаанаас би тухайн мэдээг шуурхай оруулсан.

Харин мэдээ явсаны дараагийн 10 аад хоногийн дараа над руу Тесо компаний хуулийн ажилтан утастаж ямар ч баталгаагүй мэдээ явуулж байгууллагын нэр хүндэд халдсан учир уучлалт гуй гэх мэтээр эвгүй харьцаж утсаар загнасан. Мөн тэр хар тугалга илэрсэн цагаан будаагыхаа дээжийг авчирч өг. Түүнийг дахин шинжилгээнд хамруулна гэсэн. Хэрэв хар тугалга илэрэхгүй би асуудалд орно шүү гэсэн.

Мөн тухайн үед МХЕГ-аас надаас цагаан будааны үлдэгдэл дээжийг нэхэж дахин шинжилгээнд хамруулна гэсэн. Хэрэв хар тугалга илэрэхгүй би асуудалд орно ш дээ гэсэн. МХЕГ-ийн нэр бүхий албан тушаалтаны амнаас хувийн ААН-ийн ажилтантай адилхан үг гарч байгааг би тухайн үед гайхсан ч дээжийг өгөхгүй. Хөндлөнгийн лабораторид өгнө. Учир нь шинжилгээний хариу үнэн зөв гарах эсэхэд би эргэлзэж байгааг хэлсэн.

МХЕГ-ын хувьд манай мэдээллийн мөрөөр цагаан будаанд шинжилгээ хийсэн. Харин шинжилгээний хариуг Хэвлэлийн бага хурлаар мэдэгдэнэ гэсэн. Олон хоногийн дараа гарсан шинжилгээний хариу зөвшөөрөгдөх хэмжээнээс бага гарсан гэсэн боловчиг ХБХ хийгээгүй, чимээгүй өнгөрсөн.

Цагаан будааны сэдвээр би 3 нь ч мэдээ хийсэн. Нэг нь цагаан будааны дээжийг Геологийн төв лабораторид өгч байгаагаа мэдээлж шинжилгээний хариуг хүлээсэн. Шинжилгээ зүгээр гарлаа гэсэн мэдээг надад 10 гаруй хоногийн дараа ирүүлсэн. Мөн надаас мөнгө нэхэмжилсэн.

Энэ мэдээний үеэр манай улс хүнсний хатуу бүтээгдэхүүнд хүнд металийн шинжилгээ хийх хөндлөнгийн лаборатори тоног төхөөрөмж байдаггүй гэдгийг олж мэдсэн. Энэ талаар мэдээлсэн.

Мөн цагаан будааны мэдээ хийх үеэр ажлын газрын удирдлагын зүгээс мэдээнд болгоомжтой хандахыг сануулж итгэмжлэгдээгүй лабораторийн хариуг сенсаци болгосоныг зэмлэж Тесо компанитай МҮОНРТ-ийн нэр бүхий албан тушаалсан олон сая төгрөгний сурталчилгааны гэрээтэй болохыг анхааруулж мэдээнд болгоомжтой хандахыг хүссэн. Мөн Тесо компанид миний дараагийн сэдвийг мэдээлсэн тохиолдол гарсан.

Одоогоор надад хар тугалга илэрсэн будааны дээж хадгалагдаж байгаа төдийгүй би энэ сэдвийг үргэлжүүлмээр байгаа ч хэрхэн өөрийгөө хэрэгт хийхгүйгээр үргэлжилүүлэхээ мэдэхгүй байна. Надад мэргэжил арга зүйн зөвөлгөө өгнө үү.

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн М. Бямбасүрэн

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Нийслэлийн гэх тодотголтой “Улаанбаатар радио” нь 1995 оноос эхлэн үйл ажиллагаагаа тогтвортой явуулж, Монгол Улсын Үндсэн хуулин дахь үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний мэдэх эрхийг тууштай дэмжин хэрэгжүүлж ирсэн манай салбарын ууган радионуудын нэг билээ.

Хэвлэл мэдээллийн салбар нь хүний язгуур эрх болох үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хэвлэн нийтлэх эрхийг хэрэгжүүлэгч, нийгмийн өмнө хоточ нохой байх дөрөв дэх засаглалын үүрэг хүлээдгийн хувьд эдийн засаг, санхүүгийн ялангуяа “өмчийн” хувьд хараат бусаар үйл ажиллагаа явуулах учиртай. Энэ зорилгын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2007 оны 12 сарын 28-ны өдрийн 11/65 тоот тогтоолыг үндэслэн Нийслэлийн Өмч Хувьчлах Комиссын 2008 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоол гарч Нийслэлийн өмчийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, “Баруун Сэлбэ” үйлчилгээний төвийн барилгын “Ж” блокийн 1 222 м.кв талбай бүхий байр, гүүрэн гарцыг “Улаанбаатар радио” ХХК-д хувьчилсан байдаг.

Гэвч шүүхээс Нийслэлийн өмч хувьчлах комиссийн 2008 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолыг хүчингүй болгосноор дөрөв дэх засаглалын үүрэгтэй Монголын хэвлэл мэдээллийн зах зээлд төлөвшсөн, өөрийн гэсэн сонсогчидтой мэргэжлийн сэтгүүлч, уран бүтээлчдээс бүрдсэн хамт олны өмч болох ажлын байр, олон жилийн хүч хөдөлмөр шингэсэн уран бүтээлийн ажил зогсох аюул тулгараад байна.

Нийслэлийн Улаанбаатар радио ажлын байраа 2008 онд хуулийн хүрээнд, албан ёсны гэрээний дагуу хувьчлан авсныг гэрчлэх албан ёсны бүхий л баримт нээлттэй байх атал **“хувьчлалын арга хэлбэрийг тогтоох үүргээ биелүүлээгүй”** гэх нэрийн дор арилжааны байгууллагын хувийн өмчид хууль бусаар халдах, үүгээрээ ардчилсан нийгмийн амин сүнс болсон ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ рүү халдаж буй ноцтой хэрэг хэмээн үзэж сэтгүүлчдийн эрхийг хамгаалах мэргэжлийн байгууллага, холбоод илт буруушааж байна.

Монгол улс нь ардчилсан, хүмүүнлэг иргэний нийгэм байгуулах цэх шугамыг тууштай баримталж буй өнөө цагт, нэн ялангуяа “Ардчилсан Ерөнхийлөгч”-тэй, “Ардчилсан Нам” засгийн эрхийг барьж буй энэ цаг дор өөрийн гэсэн өнгө төрх бүхий нэвтрүүлгийн бодлоготой, үнэнч сонсогчидтой болсон хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрээд байна.

Олон улсын түвшинд төр засгийн зүгээс хэвлэл мэдээллийн олон ургальч, олон талт байдлыг тууштай дэмждэг эсэх, түүнчлэн аливаа өрөөсгөл ашиг сонирхлын үүднээс хэвлэн нийтлэх эрх, сэтгүүлчдийн эрх, өмчийн харилцаанд аливаа дарамт шахалт байдаг эсэхээс тухайн улсын ардчиллын үйл явцын чухал шалгуур үзүүлэлт болдог. Нэн ялангуяа нийгмийн тодорхой хэсэг бүлэгт тогтмол хүрдэг, тэдний ашиг сонирхолд нийцсэн мэдээ мэдээллийг түгээдэг олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ тууштай биелүүлж буй мэдээллийн хэрэгслийг төрийн зүгээс эрх зүйн таатай орчин болоод санхүүжилтын тодорхой бодлогоор дэмжих хандлага нэн түгээмэл байна.

Бид олон улсын нийтлэг чиг хандлага, шилдэг сайн туршлагыг аль ч салбартаа хэрэгжүүлэхийг зорьдгийн нэгэн ижил хэвлэл мэдээллийн салбар дахь эерэг дэвшилттэй зүйлийг дэмжиж, харин хэвлэн нийтлэх эрх чөлөө, сэтгүүлчдийн хөдөлмөрлөх эрхийн

эсрэг саад тотгор бүхэнтэй тууштай тэмцэх болно. Ялангуяа сэтгүүлчдийн хөдөлмөрлөх эрхийн асуудал, ажлын байртай холбоотой асуудлаар олон улсын мэргэжлийн сүлжээ холбоодод хандаж эрх зүйн зөвлөлгөө хүсэх, мэргэжлийн дэмжлэг хүлээхэд бид үргэлж нээлттэй байдаг.

Улаанбаатар радиогийн өмчийн эрхтэй холбоотой үүсээд буй нөхцөл байдлыг салбарын мэргэжлийн байгууллага, холбоод эдийн засгийн аргаар хэвлэн нийтлэх эрх чөлөөнд илтэд халдаж буй хэсэг бүлэг хүмүүсийн явцуу ашиг сонирхолд үйлчилсэн хууль бус үйл ажиллагаа хэмээн үзэж туйлын ихээр харамсаж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллага, уран бүтээлчдийн хүч хөдөлмөр, хүсэл зорилго нь аль нэг нам хүчний шийдвэрийн золиос болох учиргүй бөгөөд үүний хохирлыг орон тооны 20 гаруй ажилтны ажлын байрны хэмжээгээр бус тэдний сонсогчдын илтгэл үнэмшил, үнэ цэнээр давхар хэмжигдэх болохыг тэмдэглэе.

Олон сараар сунжирч буй энэ хэргийг нааштай шийдэх олон арга зам байгааг бодолцон үзэж, Улаанбаатар радиогийн үйл ажиллагааг хэвийн явах, цаашид он удаан жил оршин тогтнох хувь заяаг нааштайгаар шийдвэрлэж өгнө хэмээн гүнээ найдаж байна.

Төр дөрөв дэх засаглалд төмөр нүүрээ харуулах учиргүй.

Улаанбаатар хот
2013 оны 11 дүгээр сар

МоАХ-ны удирдлагууд Засаг даргад бараалхжээ

Сүүлийн нэг сар манай хотын хэмжээнд аймгийн ЗДП-ын даргын талаар нэг бүрийн үнэн худал нь мэдэгдэхгүй тэнгү мэдүүлүүд шил шилээ даган гарч, ам дамжин яригдаж, бичигдэж байгаа билээ.

Энэ асуудал МоАХ-ны анхаарлыг ч тусархай хэмжээгээр талж ажлын зарцууллага, ёс зүйн асуудалд холбогдсон В.Сумъяасухайн асуудлыг "эцэг" -ээр авч хэлэлцжээ.

Аррхивын намын нэгдэл ажлалд томилогдож, намын нэгдэл нийгэм ахуйн хооронд Засаг даргад хандаж, арга хэмжээ авуулах асуудал яригдаж, шийдвэр гарч бичиг хүргүүлжээ.

Гэтэл холбооны зарим гишүүд нь хувь хүний асуудалд хэл өрсөөсөл хийж байгаа дахин нягтлах нь түүнтэй гэсэн санал гарснаар хэл хэлэн "таргивнууца" эрсдэлтэй хөндөгч чинээгүйн үнэн мөншөө таниулах эрхэл гаргасан.

Тэд аймгийн ЗДП-г ойрын нь сурвалжтай ажиллагааг сэтгүүрч, сурвалжлагчид, тамгын газарт ажиллаж байсан нам, намын төлөөлөгчтэй уулзаж танилцалдаг төлбөр, мэдгэйгээр үр дүн гаргээ. Игнэв хэргийн үзвэ, хэлгэргийн долоор тамгын даргын талаарх мэдээлэл нь үндэслэлгүй худал зохион

байгууламтай зохиомол гүтгэж болж, "Түгтэл" жүжгийн гол найруулагч, дэлгэч нь өөрсдийнх нь дотрогд МоАХ-ны гишүүн Шарвын Энхбаяр болж хувирагч.

Ш.Энхбаяр нь МоАХ-ны нэгдэл аймгийн ЗДП-г аж ахуйн тасгийн эрхлэгчээр томилогдон ажиллаж байгаа юм.

Түүний ийн алхам хийж болсон шалтгааныг ч тогтоожээ. Ш.Энхбаяр нь ажлын байран дээр байгаа янзүүрх ирхн ууж оотууран, ажил хийлүүдэг байдал нь ЗДП-ын даргын анхааралд оржон түүнд өөрийнхөө тухааар арга хэмжээ авсан юм байна. Мөн сүүлийн үед Ш.Энхбаярын ажлын өргөлөө талаар Засаг даргад танисан санал нь түүний чинхид хүрээ. Мөн түүнийг Хот төмөрхууцлын даргаар танин гэсэн амандаа хүргэж үеэр Ш.Энхбаяр дарга түүнд хариу барсан нь энэ гэнэ.

Нийлүү учрыг олж, хуярыг тунгасан МоАХ-ны хуардал зохиолын гишүүн и.Хүрэлтөгш, и.Ганболд нар Засаг даргын өргөнд барилдаж, тамгын даргад байгуулсан болсон аяллыг танилцуулан албан ёсоор уулзалт туйжээ.

Эцэст нь В.Сумъяасухааг залгаж шалтгаан дотор яриандаа хэвчлэлтэй байжыг анхааруулж, цал муу "Шавар"-ыга бодогорой хэмээн журмын нөмд нь хүрээ.

Хивсний очёс 5 хувь болтлоо буурчээ

Үндэсний манай үйлдвэр, дотоодын хивсны 99 хувийг хангадаг, 1500 гаруй ажилтан ажиллагсадтай "Эрдэнэт хивс" ХХК Турк улсад үйлдвэрлэсэн хивсний очёс цэвэрлэх, гүйцэтгэн боловсруулах Swell Soft машинныг шинээр суурьлуулжээ. Энэхүү машин нь хивсний үсэг талмаас нь 2 хуасгачар хуасж 5 гинөгч эксцентрикүүд хивсийг 2 талдаа хуасж цэвэр гөвдөн байна. Мөн унасан очёсыг ингэн гөлөөр функрт дэхүүлдэг бөгөөд хивсийг цэвэрлэн аяндаа халааж уур өсгөж аж.

Энэхүү машин Swell Soft нь дэлхийд 2 дахь нь бөгөөд эхний нь Турк улсын Каргал хивсний үйлдвэрт ашиглагдаж байгаа аж. Уг машинг суурьлуулснаас өмнө цэвэрлэх төмөрхүүд нь түүхий хивсний очёсыг 50 хувь бууруулж байсан бөгөөд энэхүү очёс цэвэрлэх, гүйцэтгэн боловсруулах SwellSoft машинг суурьлуулснаар хивсний очёс 5 хувь болтлоо буурчээ. Илгэснээр хувь арам хуасж байсан очёсгүй бүтээгдэхүүн гарна хэмээн холбогдон хүмүүс нь мэдэгж байна. Мөн компанийн зүүс уг машинг суурьлуулалд оролцсон инженер, техникийн болон ажилтан ажиллагсдаа хүлээн авч ялалж урамшуулсан байна.

"Эрдэнэт хивс" ХХК-ийн Залуучуудын холбоо байгуулагдлаа


Үндэсний манай үйлдвэр, Дотоодын хивсны 99 хувийг хангадаг "Эрдэнэт хивс" ХХК-ийн нийт ажиллагсдын 18-39 насны буюу 70 гаруй хувь нь залуучууд байдаг. Тус компанийн эн сэтгэл нэгтэй 700 гаруй залуучууд 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр "Эрдэнэт хивс" ХХК-ийн Залуучуудын холбоог байгууллаа. Тус холбоо нь Монголын залуучуудын холбооны зорилго, зорилт, чиг үүрэгтэй ухалдан бодлого, зорилго, зорилгоо батласан бөгөөд тус компанийн үйлдвэрүүдэд ажиллаж байгаа залуучуудын сайн сайхан төлөө цаашдын үйл ажиллагаагаа явуулах хэмээн мэдэгдээ.

"Эрдэнэт хивс" ХХК-ийн Залуучуудын холбооны гэрүүгээр С.Ганболдор, бодлого зарцуулах нарийн бичгийн даргаар Д.Ууганбаяр, үйл ажиллагаа зарцуулах нарийн бичгийн даргаар Н.Эрэмбаяр, санхүү зарцуулах нарийн бичгийн даргаар Б.Батмөнх нар томилогдон байна. Мөн холбооны гэрүүгээр, салбар хорооны даргаар 7 хүнийг томилсон бөгөөд эхлэлээр Д.Омбог, Б.Жаргалсайхан, Б.Наранцог нар ажиллахаар болжээ.

Аймгийн Прокурорын газар "А" үнэлгээ авчээ

Монгол улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Эрүүгийн хэргийн төв архиваас энэ оны 11 дүгээр сард хэдий орон нутгийн эрүүгийн хэргийн салбар архив, байгууллагын арга бодол албан хэрэг хэлэлцлийн байдал шалгалт хийжээ. Уг шалгалтаар Орхон аймгийн Прокурорын газарт хэлэлцлийн стандартад нийцсэн, шаардлага бүрэн хангасан хэмээн "А" үнэлгээ тавьжээ.

Алмаа төрийн ба төрийн бус байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад албан хэрэг хэлэлцэл чухал үүрэгтэй аж. Ажлын зөв зохион байгуулалт, архивын баримтаг холбогдон хууль тогтоомжид насны дагуу хүлээн авах, хадгалж хамгаалах, зарцуулахын дагуу ашиглуулах зэргээ тухайн байгууллагын үйл ажиллагааг хариу үүсгэлт дүгнэлт авч болдог байна.





**ОРХОН АЙМГИЙН
АРДЧИЛСАН ХОЛБОО**

"НАР ТУССАН ЦАГ" СОНИНЫ МЭДЭЭНИЙ АЛБАНД

Орхон аймаг Баян-Өндөр сум Хүрэнбулаг
баг Ардчилалын ордон
№15
Утас: 99352794 95392639
2013.12.26.

Мэдээлэлийн эх сурвалжийг авах тухай

Танай сонины 2013 оны 12 сарын 06-ны өдрийн № 36-рт бичигдсэн "МоАХ-ны удирдлагууд Засаг даргад бараалхжээ" гэсэн мэдээллийн дагуу эх сурвалжийг манай байгууллагад мэдээлэхийг хүсэж байна.

Аймгийн ардчилсан холбоо нь шудрага ёс, эрх чөлөө, иргэний нийгмийг Монгол улсын хөрс шороонд буулгах эрхэм зорилттой 24 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн нэр хүнд бүхий байгууллага юм. Бид ганцаарчилсан тоглолт буюу элдвийн хов живний араас тал тал тийш эрэл хайгуул хийдэг, хэн нэгэнд долигнон тал засагч байгууллага биш юм.

Орхон аймгийн засаг даргад 2013 оны 09 сарын 13 нд хүргүүлсэн "Зарим гишүүдийн ёс суртахууны тухай" албан бичгийн хариуг бид одоо болтол аваагүй байгаа бөгөөд тухайн үед харилцан ярилцсан үг, өгүүлбэр бүрийг ноён В.Сумьясүхийг хаацайлсан, бидний журмын нөхөр Ш.Энхбаярыг гутаан доромжилсон үгтэй болгосон танай сонины дүгнэлт нь аймгийн Ардчилсан холбооны журмын нөхөд бидний эв зөийг салган бүснүүлэх гэсэн, аймгийн ЗДТГ-ын даргад хэт дулдуйдсан мэдээлэл болсныг эсэргүүцэж байна.

Иймд танай сонин тус мэдээллийн эх сурвалжийг хэзээ, хаанаас, хэнээс авсан болохоо Орхон аймгийн Ардчилсан холбоонд албан бичгээр ирүүлнэ үү?

ОРХОН АЙМГИЙН АРДЧИЛСАН ХОЛБООНЫ ДАРГА



Д.ЭРДЭНЭЦОГТ



**"ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ"
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Дипломат 95 цогцолбор, 5-р орц, 57 тоот
Шуудангийн хаяг: Ш/х-102, Ш/салбар-38, Улаанбаатар-15141
Утас: 324764, 324627, Факс: 976-11-324764
Имэйл: hnaran@globeinter.org.mn; globenews@globeinter.org.mn;
globemon@gmail.com; цахим хуудас: www.globeinter.org.mn

2013.12.10 № 83

танай _____-ны № _____-т

Г _____ Г

Г НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР
ХЭЛТСИЙН ЦАГДААГИЙН МӨРДӨН
БАЙЦААГЧ, АХЛАХ ДЭСЛЭГЧ
Д.САЙНЖАРГАЛ Г

А.Баттөрд холбогдох хэргийг
хэрэгсэхгүй болгуулах тухай

"Өөрийгөө илчлэн ирсэн" гомдол гаргагч эмэгтэйн зургийг тайлбартай нь хамт интернэтээр түгээсэн өөр этгээд байх тул сэтгүүлч А.Баттөрд холбогдуулсан хэргийг эрүүгийн хэрэг гэж үзэхгүй байна.

www.dursamj.mn цахим хуудасны сэтгүүлч А.Баттөрд эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн, сэжигтнээр тогтоосныг дараах үндэслэлээр гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж байна.

- Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд заасан гүтгэх гэмт хэргийг үйлдсэн субъект нь уг **эмэгтэйн зургийг интернэтээр анх түгээсэн өөр этгээд байна.**
- Субъектив тал нь **"өөрийгөө мөн хэмээн илчлээд"** буй эмэгтэйг огт танихгүй тул санаатай, болгоомжгүй алив нэг санаа зорилго байхгүй.

Түүнчлэн www.dursamj.mn цахим хуудсанд тавигдсан зургийг харсан ямар ч хүн хэн болохыг таних боломжгүй атал өөрийгөө гэж илчилсэн "эмэгтэй"-н санаа зорилгыг шалган тогтоох шаардлагатай гэж үзэж байна.

Энэ зургийн эзэн нь хэн болохыг мэдэхгүй, таних боломжгүй байдлаар тус цахим хуудсанд тавигдсан гэдгийг анхааралдаа авна гэдэгт итгэж байна. Уг мэдээллийг www.dursamj.mn цахим хуудаснаас анх уншсан хүн нүүрний ихэнх хэсгийг халхалсан эмэгтэйн хэн болохыг таних боломжгүй байна. Хэрэв шаардлагатай бол энэ тухай шинжээчийн дүгнэлт гаргуулах нь зүйтэй.

Сэтгүүлч А.Баттөр нь www.chuhal.mn цахим хуудсанд нийтлэгдсэн "Интернэтээр биеэ үнэлэгчдийн жишээ" гарчигтай мэдээллээс зөвхөн зураг, гарчигийг хуулбарлан охид, эмэгтэйчүүдэд сэрэмжлүүлэг болгох үүднээс өөрийн цахим хуудсанд байрлуулжээ.

Сэтгүүлч уг мэдээллийг олон нийтэд нэгэнт түгээгдсэн хойно нь өөрийн цахим хуудсанд хуулбарлан тавьж, ёс зүйн алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч, залруулга мэдээллийг өөрийн болон бусад хэд хэдэн цахим хуудсаар дамжуулан тавьсныг **хариу өгөх эрхийг хүндэтгэж, залруулга хийж, уучлал хүсч** хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын арга хэрэглэжээ.

2000 оны 12-р сарын 1-нд НҮБ-аас гаргасан Тунхаглалд "Гишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гүтгэлгийн эсрэг эрүүгийн хуулиа нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэн, эдгээр заалтыг хүчингүй болгож, ял шийтгэл хүлээлгэхгүй байхыг" сануулсан байдаг.

Мөн 2011 оны 3-р сард Нью Йорк хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дэх хуралдаанаар Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газрын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн тухай ээлжит илтгэлийг хэлэлцээд, Монгол улсын Засгийн газарт хандан нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг Эрүүгийн хуулиас халахыг зөвлөсөн билээ.

Та НҮБ-ын дээрх зөвлөмжийг дэмжиж, чөлөөт, хараат бус хэвлэл, хэвлэлийн эрх чөлөөний мөн чанар, ач холбогдол, түүний ардчилалд оруулах хувь нэмрийг ухамсарлан ойлгож, үлгэр дууриал үзүүлэн, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэнэ хэмээн найдаж байна.

Интернэт орчинд тухайн эмэгтэйн талаар мэдээлэл оруулж, олон нийтэд тараасан этгээдийг илрүүлэх, олж тогтоох нь цагдаагийн байгууллагын бүрэн эрхийн асуудал тул эрэн сурвалжилж тогтооно гэдэгт эргэлзэхгүй байна.

Глоб Интернэшнл Төв нь 1999 онд байгуулагдсан цагаасаа эхлэн сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, мэдээлэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрхийг хамгаалах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Жич: www.dursamj.mn цахим хуудсанд гарсан зураг, хүлцэл өчсөн мэдээллийг хавсаргаав



Х.НАРАНЖАРГАЛ

**НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА
МЭДЭГДЭХ ХУУДАС**

210628 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо
Үндсэн хуулийн гудамж-3, Утас: 70109194, Факс: 70109297
Вэб: <http://www.courtservice.mn>

2013 оны 10 дугаар
сарын 29-ны өдөр

№ 3/610

Улаанбаатар
хот

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 18 ДУГААР ХОРОО,
50 ДУГААР БАЙРНЫ 14 ТООТОД
ОРШИН СУУГЧ Д.БОЛОРМАА ТАНАА**

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2012 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 383 дугаар шийтгэх тогтоолоор Д.Болормааг 7020000 төгрөгийн торгох ялаар шийтгэсэн байна.

Торгох ялын төлбөрөөс 1.000.000 төгрөгийг төлж, хүсэлт гаргасан байх тул таны Монгол Улсын хилээр нэвтрэх эрхийг түдгэлзүүлэх шийдвэрийг 2013 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр хүртэл хугацаагаар түр хойшлуулсан болно.

Торгох ялын төлбөрийн үлдэгдлийг 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор бүрэн төлж барагдуулахыг мэдэгдье.

АХЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧ,
АХЛАХ ДЭСЛЭГЧ



Б.ДАШДАВАА

НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА

ГАДААДАД ЗОРЧИХ ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН ТУХАЙ

МЭДЭГДЭХ ХУУДАС

2013.10.21

Дугаар

Улаанбаатар хот

Баянгол дүүрэг 18 дугаар хороо, 50 байрны 14 тоотод оршин суугч Дамдинсүрэнгийн Болормаа таныг Баянгол дүүргийн шүүхийн 2012 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 111.2 дугаар шийтгэх тогтоолоор 7020000 төгрөгөөр торгох ялын төлбөрийг төлөөгүй байх тул таны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлж, улсын хилээр үл нэвтрүүлэх иргэдийн нэрсийн жагсаалтанд оруулсныг мэдэгдэж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд гадаадад зорчих эрх сэргээгдэх болохыг мэдэгдье.

Мэдэгдэл хүргүүлсэн:

181 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч.....  В.Уранцэцэг

Мэдэгдэл хүлээн авсан:

Төлбөр төлөгч.....  

2013 оны 10 сарын 21 ны өдөр

10 цаг 20 минут

Хавсралт 11

Глоб Интернэшнл Төв

Монгол улсын иргэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Үндсэн хуулиар батагаажуулж өгсөн билээ.

Аймгийн ардчилсан холбоо нь сэтгүүлчийг эх сурвалжаа илчлэхийг шаардаж буй нь Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг зөрчиж буй явдал юм.

Шүүмжлэлт сэтгүүл зүй хөгжихийн хэрээр хэвлэл мэдээлэл нийгмийн “хоточ нохой” байж, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх жинхэнэ дөрөв дэх засаглал болж чадна.

Цаашид сэтгүүлчийг мэргэжлийн ажлаа хийхэд нь элдэв шахалт дарамт үзүүлж, хөндлөнгөөс оролцохгүй байхыг Танай байгууллагаас шаардаж байна. Дээрх үйлдэл давтагдах аваас бид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжигч байгууллагуудад хандаж, эрхээ хамгаалуулах болно хэмээн мэдэгдэж байна.

Асуудал хөндсөн “мэдээллийн эх сурвалж нь нууц” байдаг бөгөөд Монголын сэтгүүлчдийн эвлэлийн 15 дугаар их хурлаар батлагдсан “Монголын сэтгүүлчдийн ёс зүйн зарчим”-ийн “Мэдээллийн эх сурвалжаа нууцална”, мөн “Итгэл хүлээж олж авсан мэдээллийн уг сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг сэтгүүлч хадгалж байх” гэсэн Олон улсын сэтгүүлчдийн холбооны “Сэтгүүлчдийн баримтлах зарчим”-уудад тунхагласан байдаг. Сэтгүүлчийг ёс зүйгээ зөрчихийг шаардах нь ёс зүйн хувьд нийцэхгүй гэж үзэж байна.

Аливаа буруу, далд, бугшмал, зохисгүй үйлдэл, үйл ажиллагааг илчлэхдээ учирч болзошгүй эрсдлээс өөрийгөө хамгаалан нэрээ нууцлах нь иргэний эрх юм. Ийм ч учраас улс орнуудад шүгэлдэгч буюу мэдээлэгч, мөн сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль тогтоомж үйлчилдэг. Манай улсад одоогоор ийм хамгаалалт байхгүй байгаа нь төрийн албан тушаалтнуудын өөрсдийн буруутай үйл ажиллагааг далдлах, зөвтгөх боломж олгож буй нь харамсалтай.

Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэг мөн гэж 2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд заасан.

139 дүгээр зүйл. Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх

139.1.Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

139.2.Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Шүүмжлэлт сэтгүүл зүй хөгжихийн хэрээр хэвлэл мэдээлэл нийгмийн хоточ нохой байж, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх жинхэнэ дөрөв дэх засаглал болж чадна. Гэтэл иргэдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгосон хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүрийг хэрэгт татаж, төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагааг шүүмжилснийг нь шүүх буруутай гэж үзээд байвал Монгол улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжих боломжгүй юм.

Шуурхай мэдээ: Монгол Улс
Эх сурвалж: Глоб Интернэшнл Төв
Огноо: 2013 оны 12 дугаар сарын 9-ний өдөр

Глоб Интернэшнл Төв “Тэргүүн” сонины сэтгүүлчдэд Эрүүгийн хэргээр ял тулгаж, өндөр хэмжээний торгууль ногдуулсныг эсэргүүцэж байна

Чингэлтэй дүүргийн шүүх 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр “Тэргүүн” сонины 3 сэтгүүлчийн эсрэг Эрүүгийн хуулийн 111.2 зүйлээр үүсгэсэн хэргийг хянан хэлэлцээд нийт 29 сая төгрөгийн торгуулийн ял ногдуулж, торгох ялаас зайлсхийвэл 3 жил хүртэл хугацаатайгаар хорих ялаар солихоор шийдвэрлэжээ. Мөн 2013 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн оноосон ялыг хэвээр үлдээх шийдвэр гаргасан байна.

Глоб Интернэшнл Төв, шат шатны шүүхийн дээрх шийдвэр сэтгүүлчдийг шоронд хорихоор айлган сүрдүүлж дарамт учруулсан, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг дампуурахад хүргэж болзошгүй их хэмжээний торгууль ногдуулсан нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд учруулж буй эдийн засгийн цензур хэмээн үзэн, эсэргүүцэж байна.

“Тэргүүн” сонин 2012 оны тавдугаар сарын №19(348)-д сэтгүүлч Л.Цэдэвсүрэнгийн бичсэн “Эрдэнэтийн шүүгч нар даргынхаа ногоог тарьж, гэрийн үйлчлэгч шиг бөхөлзөж байна” нийтлэлийн дагуу Орхон аймгийн шүүхийн ерөнхий шүүгч П.Батсайхан “нэр төр, алдар хүнд гутаах зорилгоор, гүтгэлгийг олон нийтэд тараасан” гэдэг үндэслэлээр гомдол гаргасныг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд хэд хэдэн удаа түдгэлзүүлж байжээ.

Мөн тус сонины 2012 оны наймдугаар сарын №31(360)-д сэтгүүлч Б.Отгонжаргалын бичсэн “Ерөнхий сайдын охин мэргэжлийн покерчин” гарчигтай нийтлэлээс үүдэн Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн гомдлын дагуу Чингэлтэй дүүргийн шүүхээс “ажил хэргийн болон гэр бүлийн нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлэг олон нийтэд тараасан” гэсэн үндэслэлээр, түүнчлэн сонины эрхлэгч Б.Цоожчулуунцэцэгийг дээрх нийтлэлүүдийг нягталж шалгалгүйгээр “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль зөрчин, “бусдын нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэлгийг олон нийтэд тараасан” гэмт хэрэгт тус тус холбогдуулан шалгасан аж.

Чингэлтэй дүүргийн шүүхээс Ерөнхий сайд Н.Алтанхуягийн гомдлын дагуу үүсгэсэн “Тэргүүн” сонинд холбогдох эрүүгийн хэргийг өмнө нь түдгэлзүүлж байсан Орхон аймгийн шүүхийн ерөнхий шүүгч П.Батсайханы гомдлын дагуу үүсгэсэн тус сонинд холбогдох Эрүүгийн хэрэгтэй нэгтгэсэн байна. Ингээд тус шүүхээр 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр дээрх хэргүүдийг хамтатгаж, хянан хэлэлцээд, Б.Отгонжаргалыг “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэгийг олон нийтэд тараасан” гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулийн 111.2 дахь зүйлийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 7.160.400 төгрөгөөр торгох ял, Л.Цэдэвсүрэнг мөн дээрх үндэслэлээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 55 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 7.722.000 төгрөгөөр торгох ял, Б.Цоожчулуунцэцэгийг “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэгийг олон нийтэд тараасан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон гэмт хэрэг үйлдсэн” гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 14.040.000 төгрөгөөр торгох ял тус тус оногдуулжээ.

Сэтгүүлчид “Хэргийг ингэж шийдсэн нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 21.2 зүйлийг зөрчиж, хавтаст хэргийг Ерөнхий сайд Н.Алтанхуягт ашигтайгаар бүрдүүлсэн. Мэдээллийн эх сурвалж болсон гэрчүүдийг дутуу байцаасан, мэдээлэгчийг хэрэгт холбогдолгүйгээр орхисон. Мөн хуурамч мэдүүлэг дээр үндэслэн ял тулгасан. Сэтгүүлчдийн өгсөн нотлох баримтыг шалгаагүй, гэрч дуудуулах хүсэлтийг хүлээж аваагүй” хэмээн байр сууриа илэрхийлэв. Түүнчлэн цагдаагийн ажилтнууд сэтгүүлчдийг эх сурвалжаа илчлэхийг шаардах, мөн төрөх гээд өвдөж байгаа сэтгүүлч бүсгүйг “Гараад ир. Хавтаст хэрэгтэйгээ танилц” гэж дуудах, төрөөд удаагүй байхад гэрийнх нь орцонд хавтаст хэрэг дээр гарын үсэг зуруулах, өдөр бүр цаг бүртгүүлж байх үүрэг хүлээлгэх зэргээр дарамт шахалт үзүүлж байжээ.

Ардчилсан нийгэмд эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтнууд олон нийтийн хараа хяналтад байдаг, шүүмжлэлд өртөмтгий бүлэгт багтдаг болохыг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн гүтгэлэг, доромжлолтой холбоотой нэр төр гутаах асуудлыг иргэд хоорондын маргаан гэж үзэж, иргэний хуулиар шийдвэрлэдэг.

Эдгээр албан тушаалтнууд иргэний хувьд өөрийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд хүссэн хэлбэрээрээ хариу өгөх, няцаах эрхтэй. Мөн Иргэний хуулийн холбогдох зүйл заалтын дагуу нэр төрөө сэргээлгэх бүрэн боломжтой. Иймд Монгол улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийг чөлөөт, хараат бус хэвлэл, хэвлэлийн эрх чөлөөний мөн чанар, ач холбогдол, түүний ардчилалд оруулах хувь нэмэр өөрийнх нь хувийн нэр төрөөс илүү жинтэй болохыг ардчиллын төлөө тэмцэгчийнхээ хувьд ухамсарлан ойлгож, үлгэр дууриалал үзүүлэн, хэргийг Иргэний хуулийн зүйл заалтын дагуу шийдвэрлэнэ хэмээн найдаж байна.

Эрүүгийн хуулийн хатуу зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг ашиглах нь ардчилсан нийгмийн суурь зарчмын нэг хүний язгуур эрх, мөн хүн бүрийн хөгжих үндсэн нөхцөл болсон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах, иргэдэд айдас бий болгох, олон ургальч үзлийг хязгаарлах, шударга, эрүүл саруул нийгмийн хөгжилд чөдөр болдог.

2011 оны 3-р сард Нью Йорк хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дэх хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн тухай ээлжит илтгэлийг хэлэлцээд Хүний эрхийн хороо Монгол улсын Засгийн газарт хандан нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг эрүүгийн гэмт хэргээс халахыг зөвлөсөн билээ.

Глоб Интернэшнл Төв 1999 онд байгуулагдсан цагаасаа эхлэн сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, мэдээлэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрхийг хамгаалах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Глоб Интернэшнл Төв

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Дипломат 95 цогцолбор, 5-р орц, 57 тоот
Улаанбаатар-15141
Утас: 324764, 324627
И-мэйл: hnanaran@globeinter.org.mn
globenews@globeinter.org.mn
globe@globeinter.org.mn,
<http://www.globeinter.org.mn>

9 December, 2013

Globe International Center condemns over criminal defamation charges over Terguun newspaper`s journalists and imposing them a huge amount of fine.

The Chingeltei District Court reviewed on September 23, 2013 criminal case against three journalists of Terguun newspaper upon to article 111.2 of the Criminal Code and imposed fines of 29 mln.MNT (approx.US\$17.000) to them and decided “if fines are not achievable by criminals depending on the fine level sanction can be converted into prison sanction till 3 years”. Furthermore, on December 5, 2013 the Capital City Court upheld the decision of the first instance court.

Globe International Center considers the above decisions as threatening of journalists to imprisonment and economic censorship that leads the media outlet to bankruptcy and expresses its protests.

L.Tsedevsuren, male journalist published a press article titled “Judges of Erdenet are farming vegetables and stooping like steward of their bosses” on Terguun newspaper dated on May 2012, edition number 19/348/. Following the article chief justice of Orkhon Province P.Batsaikhan filed criminal charges against the journalist accusing him of publicly defaming his reputation. The case was several times at investigation stages suspended.

Furthermore, D.Otgonjargal, female journalist published a press article titled “Daughter of prime minister is `professional` poker player” on Terguun newspaper dated on August 2012, edition number 31/360/. After the article was published, Chingeltei District Court filed criminal charges against the journalist following complaint of the Prime Minister N.Altankhuyag who accused the journalist of publicly defaming his business and family reputation. Moreover the Court filed criminal charges against newspaper`s editor-in-chief Ms.B.Tsoojchuluuntsetseg on the ground of not reviewing the above mentioned two publications and violating the Law on Media Freedom as stipulated “Media shall have the responsibility for their published or broadcast information” and spreading defaming information in order to defame others name and dignity on purpose.

The criminal cases brought by the Prime Minister and P. Batsaikhan against Terguun newspaper`s journalists were merged by Chingeltei District Court. On September 23, 2013 the court sentenced B.Otgonjargal according to the Criminal Code, provision 111.2 to pay compensation 51 times higher than the minimum wage or 7.160.400 MNT (approx.US\$4350), L.Tsedevsuren - 55 times higher than the minimum wage or 7.722.000 MNT (approx.US\$4700) and B.Tsoojchuluuntsetseg – 100 times higher than the minimum wage or 14.040.000 MNT (approx.US\$8500).

According to the sentenced journalists “The court decision violates Article 21.2 of the Criminal Procedure Code and the files were collected profitably to the Prime Minister N.Altankhuyag. The information sources or witnesses were not properly questioned. Moreover, we were sentenced based on a false testimony. The evidence given by the journalists was not reviewed. The request to question witnesses was not considered.” Further, police officers demanded to reveal information sources; called from outside the maternity hospital the female journalist who had a birth pangs “Come out and read your files”; the journalist soon afterwards giving birth was demanded to sign a file in her apartment`s entrance.

Globe International protests against the court decision as it may lead the media outlet to financial difficulty and eventually it could turn into economic censorship.

Globe International believes, Prime Minister N.Altankhuyag as a democracy fighter would realize that the free and independent media, its essence and contribution to the democracy are much important than his reputation and would set an example to decide the case according to the Civil Code.

The UN Human Rights Committee discussed the report of the Mongolian Government on the ICCPR by its meeting No 101 held on March 14-21, 2011 in New York and produced the following Concluding Observations on implementation of the recommendation No25 concerning Article 19 “The State party should ... consider decriminalizing defamation...” The Government shall submit the implementation report to the UN Human Rights Committee in 2015.

Globe International Center is a nongovernmental organization which has vigorously acted to protect the rights of journalists and the freedom of the media and information since its establishment in 1999.

For more information:

Globe International Center

Chingeltei district, Khoroo 4,
Diplomat 95 Complex, Entrance 5, #57,

Ulaanbaatar, Mongolia

Phone/fax: +976 11 324764

Phone: +976 11 324627

E-mail: hnaran@globeinter.org.mn

globenews@globeinter.org.mn

globe@globeinter.org.mn

<http://www.globeinter.org.mn>



**"ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ"
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Дипломат 95 цогцолбор, 5-р орц, 57 тоот
Шуудангийн хаяг: Ш/х-102, Ш/салбар-38, Улаанбаатар-15141
Утас: 324764, 324627, Факс: 976-11-324764
Имэйл: hnaran@globeinter.org.mn; globenews@globeinter.org.mn;
globemon@gmail.com; цахим хуудас: www.globeinter.org.mn

2013.12.09 № 82
танай _____-ны № _____-т

Эрүүгийн хэргийн тухай

Монгол улсын Ерөнхий сайд Таны гомдлын дагуу "Тэргүүн" сонины сэтгүүлчдэд Чингэлтэй дүүргийн шүүхээс 20 гаруй сая төгрөгийн торгуулийн ял ногдуулж, торгох ялаас зайлсхийвэл 3 жил хүртэл хугацаатайгаар хорих ялаар солихоор шийдвэрлэсэн, мөн Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн оноосон ялыг хэвээр үлдээх шийдвэр гаргасан байна.

Глоб Интернэшнл Төв нь дээрх хэргийг иргэний журмаар шийдэх боломжтой гэж үзэж байгаа бөгөөд сэтгүүлчдэд Эрүүгийн хуулиар ял тулгасан, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаагдахад хүргэж болзошгүй өндөр хэмжээний торгууль ногдуулсан нь эдийн засгийн цензур хэмээн эсэргүүцэж байна.

Монгол улсын Ерөнхий сайд Та бол төрийн өндөр албан тушаалтан. Та иргэний хувьд өөрийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлд хүссэн хэлбэрээр хариу өгөх эрхтэй. Та нэр төрөө хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлүүлэх боломжтой.

2000 оны 12-р сарын 1-нд НҮБ-аас гаргасан Тунхаглалд "Гишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гүтгэлгийн эсрэг хуулиа нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэхийг" сануулсан байдаг.

Мөн 2011 оны 3-р сард Нью Йорк хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дэх хуралдаанаар Хүний эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газрын Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн тухай ээлжит илтгэлийг хэлэлцээд, Монгол улсын Засгийн газарт хандан нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг Эрүүгийн хуулиас халахыг зөвлөсөн билээ. Монгол Улсын Засгийн газар дээрх Пактын хэрэгжилтийн тухай ээлжит илтгэлээ НҮБ-ын Хүний эрхийн хороонд илгээх хугацаа 2015 онд тохионо.

Ерөнхий сайд Н.Алтанхуяг Таныг Монгол улсын Засгийн газрыг тэргүүлж буйн хувьд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд манлайлна гэдэгт итгэж байна.

Та энэ хэргээ ухаалгаар шийдэх нь олон улсын тавцан дээр Монгол улсын Засгийн газар болон Ерөнхий сайд Таны нэр хүндэд зэрэгээр нөлөөлнө.

Та НҮБ-ын дээрх зөвлөмжийг дэмжиж, чөлөөт, хараат бус хэвлэл, хэвлэлийн эрх чөлөөний мөн чанар, ач холбогдол, түүний ардчилалд оруулах хувь нэмрийг өөрийнхөө хувийн нэр төрөөс илүү жинтэй болохыг ухамсарлан ойлгож, үлгэр дууриал үзүүлэн, хэргийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд санхүү, эдийн засгийн дарамт үзүүлэхгүйгээр, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэнэ хэмээн найдаж байна.

Глоб Интернэшнл Төв нь 1999 онд байгуулагдсан цагаасаа эхлэн сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, мэдээлэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрхийг хамгаалах чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага юм.

Жич: Глоб Интернэшнл Төвийн "Тэргүүн" сонинтой холбоотой шуурхай мэдээ



Х.НАРАНЖАРГАЛ



Орон нутгийн өмгөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөр

2013 оны 10 сарын 28-ны өдөр

Бишрэлт зочид буудал, 201 тоот

- 09.00-09.25 Оролцогчдыг бүртгэх, мэдээлэл өгөх
- 09.30-09.40 Нээлт:
Х.Наранжаргал, “Глоб Интернэшнл төв” ТББ
- 09.40-10.20 “Үзэл бодлын эрх чөлөө ба түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө”,
Х.Наранжаргал, “Глоб Интернэшнл төв” ТББ-ын тэргүүн
- 10.20-10.30 *Асуулт, хариулт*
- 10.30-11.00 “Хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин”
Д.Мөнхбүрэн, “Глоб Интернэшнл төв”, ТББ-ын хуульч
- 11.00-11.10 *Асуулт, хариулт*
- 11.10-11.20 *Цайны завсарлага*
- 11.20-11.50 “Төрийн байгууллагын ил тод байдал ба мэдээлэл олж авах эрх”,
Х.Наранцэцэг, “Глоб Интернэшнл төв” ТББ-ын ажилтан
- 11.50-12.00 *Асуулт, хариулт*
- 12.00-13.30 *Үдийн хоол***
- 13.30-15.30 *АНУ-ын хуульч Дэниэл Байрон*
Гүтгэлэг: АНУ-ын болон олон улсын хууль
- *Үндэслэл ба тодорхойлолт*
- *Элементүүд*
- *Өмгөөллийн онцлог*
- *Анхаарах асуудлууд*
- 15.30-15.40 *Цайны завсарлага*
- 15.40-16.00 *Асуулт, хариулт*
- 16.00-17.00 **Вэбсайт дахь зохицуулалтын асуудал**
- 17.00-17.20 *Асуулт, хариулт*
- 17.20-17.30 Дүгнэлт, Д.Мөнхбүрэн, “Глоб Интернэшнл төв” ТББ-ын хуульч



Training Program for Defense Lawyers

28 October, 2013

ishreht hotel, room # 201

- 09.30-09.40 Opening speech
Kh.Naranjargal, "Globe International Center" President and CEO
- 09.40-10.20 **Right to opinion and freedom to express**
Kh.Naranjargal, "Globe International Center" President and CEO
- 10.20-10.30 *Question and answer*
- 10.30-11.00 **Media Law environment in Mongolia**
D.Munkhburen, "Globe International Center", Lawyer
- 11.00-11.10 *Question and answer*
- 11.10-11.20 *Coffee break*
- 11.20-11.50 **"Law on Information Transparency and Right to information",**
Kh.Narantsetseg, "Globe International Center", Program coordinator
- 11.50-12.00 *Question and answer*
- 12.00-13.30 *Lunch*
- 13.30-15.30 Daniel P.Byron, Lawyer USA
Law of Defamation. U.S. and International
- 15.30-15.40 *Coffee break*
- 15.40-16.00 *Question and answer*
- 16.00-17.00 **Internet regulation: Web-sites and Bloggers**
- 17.00-17.20 *Question and answer*
- 17.20-17.30 Conclusion, D.Munkhburen, "Globe International Center", Lawyer



“Глоб Интернэшнл төв” ТББ



Нээлттэй нийгэм форум

Өмгөөлөгчдөд зориулсан сургалтад оролцох хүмүүсийн нэрс**2013 оны 10 сарын 28-ны өдөр****Бишрэлт зочид буудал, 201 тоот**

№	АЙМАГ	НЭР	УТАС
1	Орхон	Р.Цэрэнханд	99088174
2		Н.Энхтуяа	99357258
3	Дархан	Ө.Өлзиймаа	99030531
4		Н.Баярмаа	99043038
5	Булган	Г.Эрдэнэчимэг	99924508
6		И.Дагиймаа	99028233
7	Сэлэнгэ	Д.Эрдэнэ-Оргил	99366663
8	Өмнөговь	И.Олонмөнх	99832053
9	Хөвсгөл	Номин-Эрдэнэ	99029085
10	Website Association	Жаргалсайхан	99113182
11	ТВ9-д байсан	Долгор	88116775



Daniel Byron

Partner

Team Leader - Media and First Amendment Law

Byron has experience in the areas of media law, intellectual property and complex business litigation. He was First Assistant United States Attorney, U.S. Southern District of Indiana from 1967 to 1969. Byron earned his undergraduate degree in 1959 from Indiana University, A.B., his law degree in 1962 from Indiana University Maurer School of Law, J.D., and his admission into the Indiana Bar in 1962. He served in the

U.S. Army (Inf. and J.A.G.), with active duty from 1962-1966.

Dan has tried a number of jury and court trials over the years in state and federal courts, and has briefed and argued appellate cases before the Indiana Court of Appeals, the Indiana Supreme Court and the 7th U.S. Circuit Court of Appeals. Dan also briefed and argued the case of *Fritz v. U.S. Railroad Retirement Board*, a class action suit, before the Supreme Court of the United States. A number of his trials involved tobacco litigation, takeover litigation, City of Indianapolis civil rights litigation, utility litigation, and a variety of media law cases representing print and broadcast companies.

In 2007, he was selected by the International Senior Lawyers Project to lead a team of West African attorneys working in Ghana, Nigeria and Sierra Leone to end impunity for violence against journalists, publishers and broadcasters and combat laws that limit freedom of expression in those countries (Nov. - Dec. 2007). For history of the trip and updates of the cases handled, see www.dbyroninghana.blogspot.com.

In 2011, he was selected by Harvard Law School's Berkman Center for Internet and Society as an Indiana media attorney to participate in its pro bono initiative representing journalists and others in need of such help.

Through the Berkman Center he was selected by the National Domestic Violence Registry to be its counsel with special emphasis on media law issues. The mission of this organization is to compile and publish a national list of the names and photographs of convicted domestic violence abusers and to inform the public of these individuals.

In 2012 he was again selected by the International Senior Lawyers Project to travel to Mongolia for one month (Sept. 1 to Oct. 1) to mentor a number of defense attorneys who have undertaken cases relating to the protection of journalists and the rights of free press and free speech. He conducted training workshops for judges, prosecutors, journalists and media companies regarding defamation cases including sedition, criminal libel and civil libel matters. International

law as well as the law of Mongolia and the United States was addressed. For history of the trip, see www.dbyroninmongolia.blogspot.com.

Also in 2012, Dan was appointed to the advisory board of the Center for International Media Law and Policy Studies, a new research center of the Indiana University School of Journalism which is the first of its kind at a public university in the United States. Dan was also appointed to the Military Affairs Committee of the Indiana State Bar Association, which was formed in 2012 to assist deployed soldiers and their families who are in need of pro bono legal help.

He was awarded the Lifetime Achievement Award by the Indiana Broadcasters Association in October, 2008, for especially meritorious service and contributions in the field of broadcasting, the association's highest honor. He is the first non-broadcaster to receive the award.

Practice Areas

- [Litigation](#)
- [Media and First Amendment Law](#)

Professional Memberships and Affiliations

- Indianapolis Bar Association
- Indianapolis Bar Foundation, Fellow
- Indiana State Bar Association, Former Chair, BARPAC
- Indiana State Bar Foundation, Fellow
- Seventh Circuit Bar Association, Former Chair, Indiana Criminal Law Section

Professional Leadership

- Indiana Debate Commission, 2007 - present
- Indiana Coalition for Open Government, 2006 - present
- The Indianapolis Athletic Club, 1999 - 2004
- The Commission for Downtown Indianapolis, Inc. 1991 - 1993

Civic and Charitable Involvement

- Thomas Moore Society of Indianapolis
- The Dramatic Club
- Meridian Hills Country Club

Honors & Awards

- Selected for inclusion in *The Best Lawyers in America*®, 2007 - 2014, in the fields of First Amendment Law and Litigation - First Amendment
- Lifetime Achievement Award, Indiana Broadcasters Association, 2008
- Inaugural winner of the 2004 Indiana State Bar Association's Civility/Professionalism Award for outstanding integrity and civility in working with judges, attorneys, parties, witnesses and the public

Representative Cases & Achievements

- *Canarx v. LIN-TV Corp et al.*, Case No. 1:07-cv-01482-LJM-JMS (U.S. Southern District of Indiana, Sept. 3, 2008)
- *Commonwealth Edison Company of Indiana Inc. v. State Board of Tax Commissioner*, Case No. 49T10-9507-TA-67, et al. (Ind. Tax Ct., 2002)
- *Jean Poulard v. The News-Dispatch Publishing Co., Inc.*, Case No. 46D02-0004-CP-080 (Ind. Ct. of Appeals, Aug. 20, 2003)
- *Eli Lilly v. Dr. Reddy's Laboratories, et al.*, So. District of Indiana, Case No. IP01-0443 CY/S (2001 – 2008)

Military Service

- U.S. Army, Inf. and J.A.G., active duty, 1962-1966

Pro bono service

We encourage our attorneys to incorporate pro bono work into their practice every year. Our attorneys are committed to being involved in organizations such as the National Domestic Violence Registry, whose mission is to provide the public with conviction records of offenders, who have been found guilty of domestic violence and domestic violence-related offenses. Partner **Daniel Byron**, who concentrates his practice in the First Amendment media law area, serves as general counsel with special emphasis on media law issues for this national organization.

Byron has also performed international pro bono work. In 2007, the International Senior Lawyers Project selected Byron to lead a team of West African attorneys to end impunity for violence against journalists, publishers and broadcasters and combat laws that limit freedom of expression. Specifically, Byron helped leading Gambian editor Musa Saidu Khan sue Gambia in West Africa's human rights forum after he was allegedly tortured by the state for publishing the names of opposition figures who were arrested after a failed coup in 2006. His work in West Africa proved not to be his last.

In 2012, he was again selected by ISLP, this time to travel to Mongolia. His mission was to mentor defense attorneys who have taken on cases relating to the protection of journalists and advancing free press and free speech issues. During his monthlong trip, Byron worked with attorneys at Clifford Chance and Baker & McKenzie and had the opportunity to give lectures to law and journalism students, employees, and broadcast and newspaper reporters. He also had the opportunity to give a seminar on international and U.S. standards on free press and free speech to trial judges to assist them in liberating their views of free press and free speech. Bingham Greenebaum Doll LLP is proud to partner with other prestigious legal organizations when participating in these international pro bono projects.

<http://www.bgdlegal.com/professionals/801/daniel-byron/>